

ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ ХК
(Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж)

Аудитлагдсан санхүүгийн тайлан

2017 оны 12 дугаар сарын 31



Building a better
working world

ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ ХК

АГУУЛГА	ХУУДАС
КОМПАНИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	1
ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ	2
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3 – 5
АШИГ АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН	6
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	7
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛГИЙН ТАЙЛАН	8
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	9 – 10
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД	11 – 46

ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ ХК

КОМПАНИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

- ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ : Ганболдын Энхтайван
- ЕРӨНХИЙ НИЯГТЛАН : Чимид-Очирын Соронзонболд
- АЛБАН ХАЯГ : 106 Бизнес Таур
1-р хороо, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар хот—14210, Монгол Улс
- ХАРИЛЦАГЧ БАНКУУД : Худалдаа Хөгжлийн Банк ХХК
Улаанбаатар Банк ХХК
Хаан Банк ХХК
Капитрон Банк ХХК
Хаан Банк ХХК
Капитрон Банк ХХК
Хас Банк ХХК
Төрийн Банк ХХК
Голомт Банк ХХК
- АУДИТОР : Эрнст энд Янг Монголия Аудит ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ ХК

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

Хөдөө Аж Ахуйн Давхар Даатгал ХК (цаашид “Компани” гэх)-ийн Гүйцэтгэх захирал Ганболдын Энхтайван болон Компанийн санхүүгийн тайланг хариуцсан Ерөнхий нягтлан Чимид-Очирын Соронзонболд бид энэхүү тайлангийн 6 – 46 дугаар хуудсанд үзүүлсэн Компанийн санхүүгийн тайлангууд нь 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны гүйцэтгэл, мөнгөн гүйлгээг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (“НББОУСЗ”) - өөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”) - уудад нийцүүлэн бэлтгэсэн Компанийн Нягтлан Бодох Бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.



Ганболдын Энхтайван
Гүйцэтгэх захирал



Чимид-Очирын Соронзонболд
Ерөнхий нягтлан

Улаанбаатар хот, Монгол улс
Огноо: 2018.02.28.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧ ТАНАА:

Аудиторын дүгнэлт

Бид Хөдөө Аж Ахуйн Давхар Даатгал ХК (цаашид “Компани” гэх)-ийн 2017 оны 12 сарын 31-ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-уудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлт гаргах үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (“АОУС”)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн “Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага” хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан “Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм”-ийн дагуу Компаниас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан хязгаарлалттай дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Санхүүгийн тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Аудиторын хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖ.)

ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧ ТАНАА (ҮРГЭЛЖ.):

Аудиторын хариуцлага (үргэлж.)

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч “АОУС”-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

“АОУС”-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлттэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгддэг.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖ.)

ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧ ТАНАА (ҮРГЭЛЖ.):

Бусад зүйл

Компанийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлангууд нь өөр аудитороор баталгаажуулагдсан бөгөөд 2017 оны 3 дугаар сарын 30-ний өдөр өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн байна.

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчийн захиалгаар аудитыг гүйцэтгэн гагцхүү Компанийн хувьцаа эзэмшигчид зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Ernst & Young Mongolia Audit LLC

ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид



ПЕТР МАРКИ
Захирал

Улаанбаатар хот, Монгол Улс

Огноо: 2018.02.20

ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ ХК
2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН
АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

	Тодруулга	2017 Мян.төг	2016 Мян.төг (Дахин толил. *)
Даатгалын нийт хураамжийн орлого	4	1,851,623	994,613
Давхар даатгалын хураамж	5	(800,423)	(352,811)
Даатгалын цэвэр хураамжийн орлого		1,051,200	641,802
Нийт төлсөн нөхөн төлбөр	6	—	(4,614)
Нөөц сангийн өөрчлөлт		(206,219)	(367,344)
Нөхөн төлбөрийн цэвэр зардал		(206,219)	(371,958)
Хөрөнгө оруулалтын орлого	7	5,814,162	4,439,231
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	8	101,810	71,135
Үйл ажиллагаа, ерөнхий удирдлагын зардал	9	(1,908,232)	(1,534,775)
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	10	(129,027)	(69,165)
Татвар төлөхийн өмнөх ашиг		4,723,694	3,176,270
Орлогын татварын зардал	11	(404,011)	(195,621)
Татварын дараах ашиг		4,319,683	2,980,649

* Тодруулга 29-нд тусгагдсан залруулгуудын нөлөөллөөр зэрэгцүүлсэн дүнгүүд нь өмнөх үеийн тайлангын дүнгүүдээс дахин толилуулагдсан болно.

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн саллигүй хэсэг болно.

ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ ХК
2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	Тодруулга	2017 Мян.төг	2016 Мян.төг (Дахин толил.*)	2015 Мян.төг (Дахин толил.*)
ХӨРӨНГӨ				
Эргэлтийн бус хөрөнгө				
Үндсэн хөрөнгө	12	363,229	639,221	350,869
Биет бус хөрөнгө	13	423,300	467,660	6,930
		<u>786,529</u>	<u>1,106,881</u>	<u>357,799</u>
Эргэлтийн хөрөнгө				
Хадгаламж, үнэт цаас	14	41,635,403	32,889,362	16,997,271
Давхар даатгалын хойшлогдсон хураамж	22	205,193	428,089	—
Бараа материал	15	—	8,312	3,133
Урьдчилж төлсөн зардал болон бусад авлага	16	315,597	721,782	591,726
Даатгалын хураамжийн авлага	17	20,721	128,953	156,007
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	18	431,186	231,318	8,509,843
		<u>42,608,100</u>	<u>34,407,816</u>	<u>26,257,980</u>
НИЙТ ХӨРӨНГӨ		<u>43,394,629</u>	<u>35,514,697</u>	<u>26,615,779</u>
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ				
Эздийн өмч				
Эзэмшигчдийн өмч	19	15,000,000	15,000,000	15,000,000
Эздийн өмчийн бусад хэсэг	20	489,264	684,333	86,477
Алдагдлаас хамгаалах нөөц сан	21	15,000,000	9,500,000	7,000,000
Хуримтлагдсан ашиг		7,669,695	5,384,758	2,404,109
Нийт эздийн өмч		<u>23,158,959</u>	<u>21,069,091</u>	<u>17,490,586</u>
Өр төлбөр				
Хамтын эрсдлийн сан	22	1,165,807	846,426	591,057
Эрсдлээс хамгаалах нөөц сан	22	3,270,696	3,065,791	513,195
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц	22	460,217	1,008,702	—
ААНОАТатварын өглөг		131,002	21,519	39,341
Урьдчилж олсон орлого болон бусад өглөг	23	105,950	3,168	981,600
Давхар даатгагчид өгөх өглөг	24	101,998	—	—
Нийт өр төлбөр		<u>20,235,670</u>	<u>14,445,606</u>	<u>9,125,193</u>
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		<u>43,394,629</u>	<u>35,514,697</u>	<u>26,615,779</u>

* Тодруулга 29-нд тусгагдсан залруулгуудын нөлөөллөөр зэрэгцүүлсэн дүнгүүд нь өмнөх үеийн тайлангын дүнгүүдээс дахин толилуулагдсан болно.

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ ХК
2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ЭЗДИЙН ӨМЧИЙН ӨӨРЧӨЛӨЛТИЙН ТАЙЛАН**

	Эзэмшигчдийн өмч Мян.тог (Тодруулга 19)	Алдаглаас хамгаалах нооц сан Мян.тог (Тодруулга 21)	Эздийн өмчийн бусад хэсэг Мян.тог (Тодруулга 20)	Хуримтлагдсан ашиг Мян.тог	Нийт Мян.тог
2016.01.01-ээр (Дахин толилуулсан*)					
Алдаглаас хамгаалах нооц сангийн өөрчлөлт	15,000,000	7,000,000	86,477	2,404,109	24,490,586
Эздийн өмчийн бусад хэсгийн өөрчлөлт	—	2,500,000	—	—	2,500,000
Нийт дэлгэрэнгүй орлого	—	—	597,856	—	597,856
				2,980,649	2,980,649
2016.12.31-ээр болон 2017.01.01-ээр (Дахин толилуулсан*)					
Эздийн өмчийн бусад хэсгийн өөрчлөлт	15,000,000	9,500,000	684,333	5,384,758	30,569,091
Алдаглаас хамгаалах нооц сангийн өөрчлөлт	—	—	(195,069)	(34,746)	(229,815)
Нийт дэлгэрэнгүй орлого	—	5,500,000	—	(2,000,000)	3,500,000
				4,319,683	4,319,683
2017.12.31-ээр	15,000,000	15,000,000	489,264	7,669,695	38,158,959

* Тодруулга 29-нд гусгагдсан залруулгуудын нөлөөллөөр зэрэгцүүлсэн дүнгүүд нь өмнөх үеийн тайлангын дүнгүүдээс дахин толилуулагдсан болно.

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн саллигүй хэсэг болно

ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ ХК
2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	Тодруулга	2017 Мян.төг	2016 Мян.төг (Дахин толил.*)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Татварын өмнөх ашиг		4,723,694	3,176,270
<i>Татварын өмнөх ашигийг цэвэр мөнгөн гүйлгээтэй тохируулах мөнгөн бус тохируулгууд:</i>			
Валютын ханшийн бодит бус олз	8	(1,693)	—
Үндсэн хөрөнгийн элэгдэл	9	86,476	54,610
Үндсэн хөрөнгө шилжүүлсний олз	8	(233)	—
Үндсэн хөрөнгө дансаас хассаны гарз	10	6,217	—
Биет бус хөрөнгийн хорогдуулга	9	47,330	694
Хүүний орлого	7	(5,814,162)	(4,439,231)
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл			
Ажиллагааны алдагдал		(952,371)	(1,207,657)
<i>Ажлын капиталын тохируулга:</i>			
Хураамжийн авлагын бууралт		108,232	27,053
Урьдчилж төлсөн зардал болон бусад авлагын бууралт/(өсөлт)		416,958	(76,828)
Бараа материалын бууралт/(өсөлт)		8,312	(5,179)
Давхар даатгагчийн хойшлогдсон хураамжийн бууралт/(өсөлт)		222,896	(428,089)
Давхар даатгагчид өгөх өглөгийн өсөлт		105,727	—
Бусад өглөгийн өсөлт/(бууралт)		102,782	(978,432)
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сангийн өсөлт/(бууралт)		(548,485)	1,008,702
Хамтын эрсдлийн сангийн өсөлт		319,381	255,369
Эрсдлээс хамгаалах нөөц сангийн өсөлт/(бууралт)		170,159	2,552,596
Үйл ажиллагаанд зарцуулсан (–аас орсон) мөнгөн гүйлгээ		(46,409)	1,147,535
Төлсөн орлогын албан татвар		(294,528)	(213,443)
Үйл ажиллагаанд зарцуулсан (–аас орсон) цэвэр мөнгөн гүйлгээ		(340,937)	934,092
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	12	(11,536)	(206,529)
Биет бус хөрөнгийн худалдан авалт	13	(2,970)	—
Хүлээн авсан хүү		5,803,389	4,386,003
Гурван сараас дээш хугацаатай банкуудад байршуулсан хадгаламжийн өөрчлөлт		(8,746,041)	(15,892,091)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ		(2,957,158)	(11,712,617)

ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ ХК
2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (ҮРГЭЛЖ.)

	Тодруулга	2017 Мян.төг	2016 Мян.төг (Дахин толил.)*
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ			
МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Алдагдлаас хамгаалах нөөц санг өсгөхөд орсон		3,500,000	2,500,000
Санхүүгийн үйл ажиллагаанаас орсон цэвэр мөнгөн гүйлгээ		<u>3,500,000</u>	<u>2,500,000</u>
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт/(бууралт)		201,905	(8,278,525)
Валютын ханшийн нөлөөлөл		(2,037)	—
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		231,318	8,509,843
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18	431,186	231,318
Мөнгөн бус санхүүгийн үйл ажиллагаа			
Сангийн Яам руу шилжүүлсэн үндсэн хөрөнгө	12	(194,836)	—
Сангийн Яамнаас шилжүүлэн авсан үндсэн хөрөнгө	12	—	136,432
Сангийн Яамнаас шилжүүлэн авсан биет бус хөрөнгө	13	—	461,424
		<u>(194,836)</u>	<u>597,856</u>

* Тодруулга 29-нд тусгагдсан залруулгуудын нөлөөллөөр зэрэгцүүлсэн дүнгүүд нь өмнөх үеийн тайлангын дүнгүүдээс дахин толилуулагдсан болно.

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салигүй хэсэг болно

1. КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ ХК (цаашид “Компани” гэх) нь Монгол улсад бүртгэлтэй, тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг хувьцаат компани юм. Компанийн үндсэн үйл ажиллагаа явуулдаг, албан хаяг нь Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Бизнес Таур-10б.

Компанийн гол үйл ажиллагаа нь хөдөө аж ахуйн давхар даатгалын үйлчилгээ юм. Компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2015 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр №48 дугаар тушаалаар батлагдан олгосон 220/02 дугаартай тусгай эрхийн дагуу үйл ажиллагаа явуулдаг.

Компани нь Монгол улсын төрийн өмчит байгууллага болно.

Хөдөө Аж Ахуйн Давхар Даатгал ХК-ний ТУЗ-ын 2018 оны 2 дугаар сарын 28-ний өдрийн шийдвэрээр Компанийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланг баталж, нийтэд мэдээлэхийг зөвшөөрсөн.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД

2.1 Тайлан бэлтгэх үндэслэл

Компанийн санхүүгийн тайлангууд нь НББОУСЗ-өөс гаргасан СТОУС-ын дагуу бэлтгэгдсэн. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг түүхэн өртгийн зарчмаар бэлтгэсэн болно. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг Компанийн үйл ажиллагааны мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр толилуулсан. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр зааснаас бусад тохиолдолд мянганы орноор тайлагнасан.

2.2 Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогод орсон өөрчлөлтүүд

Шинэчлэгдсэн болон нэмэлт өөрчлөлт орсон стандартууд

2017 оны 1-р сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон доорхи СТОУС-уудаас бусад Компанийн хэрэгжүүлж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь өмнөх санхүүгийн жилийнхтэй адил юм:

- | | |
|---------------------------------------|---|
| • НББОУС 7 Нэмэлт өөрчлөлт | <i>НББОУС 7 Нэмэлт өөрчлөлт – Тодруулга дахь санаачлага</i> |
| • НББОУС 12 Нэмэлт өөрчлөлт | <i>НББОУС 12 Нэмэлт өөрчлөлт – Орлогын албан татвар: Бодит бус гарзад хойшилогдсон татварын хөрөнгийн хүлээн зөвшөөрөх нь</i> |
| • Жилийн сайжруулалт (2014-2016 цикл) | <i>2016 оны 12 сард гаргасан СТОУС-уудад орсон нэмэлт өөрчлөлт</i> |

Эдгээр стандарт, нэмэлт өөрчлөлт, тайлбаруудыг дагаж мөрдөхөд Компанийн санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлээгүй болно.

Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд

Компанийн санхүүгийн тайлангуудыг гаргах өдрийн байдлаар батлагдаж гарсан боловч хэрэгжиж эхлээгүй байсан стандартуудын жагсаалтыг дор үзүүлэв. Компани нь энэхүү стандартуудыг хүчин төгөлдөр үйлчилж эхлэх өдрөөс мөрдөхөд боломжтой байна.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖ.)

2.2 Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогод орсон өөрчлөлтүүд (үргэлж.)

Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд (үргэлж.)

- | | |
|---|---|
| • СТОУС 2 Нэмэлт өөрчлөлт | <i>СТОУС 2 Нэмэлт өөрчлөлт – Хувьцаанд суурилсан төлбөрийн гүйлгээний ангилал ба хэмжилт ¹</i> |
| • СТОУС 4 Нэмэлт өөрчлөлт | <i>СТОУС 4 Нэмэлт өөрчлөлт – СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр-г СТОУС 4 Даатгалын гэрээнд тусгах ¹</i> |
| • СТОУС 9 | <i>Санхүүгийн хэрэглүүр ¹</i> |
| • СТОУС 10 болон НББОУС 28, Нэмэлт өөрчлөлт | <i>СТОУС 10 болон НББОУС 28, Нэмэлт өөрчлөлт - Хөрөнгө оруулагч болон түүний хараат Компани эсвэл Хамтарсан хэлцэл хооронд Хөрөнгө борлуулах эсвэл оруулах ⁴</i> |
| • СТОУС 15 | <i>Харилцагчтай байгуулсан гэрээний дагуух орлого ¹</i> |
| • СТОУС 16 | <i>Түрээс ²</i> |
| • СТОУС 17 | <i>Даатгалын гэрээ ³</i> |
| • СТОУС 9 Нэмэлт өөрчлөлт | <i>СТОУС 9 Нэмэлт өөрчлөлт –Сөрөг нөхвөртэй урьдчилж төлсөн зардлын онцлог²</i> |
| • НББОУС 28 Нэмэлт өөрчлөлт | <i>НББОУС 28 Нэмэлт өөрчлөлт –Хөрөнгө оруулагч болон түүний хараат Компани эсвэл Хамтарсан хэлцэл хооронд Хөрөнгө борлуулах эсвэл оруулах ²</i> |
| • НББОУС 40 Нэмэлт өөрчлөлт | <i>НББОУС 40 Нэмэлт өөрчлөлт – Хөрөнгө оруулалтын хөрөнгийн шилжүүлэг¹</i> |
| • СТОУТХ Тайлбар 22 | <i>Гадаад валютаарх гүйлгээ болон урьдчилгаа төлбөр ¹</i> |
| • СТОУТХ Тайлбар 23 | <i>Орлогын албан татварын бүртгэлийн тодорхойгүй байдал ²</i> |
| • Жилийн сайжруулалт (2014-2016 цикл) | <i>СТОУС-уудын өөрчлөлт ¹</i> |

¹ 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

² 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

³ 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

⁴ Уг өөрчлөлтийн хүчин төгөлдөр болох өдрийг СТОУСЗ-ийн өмчийн аргын бүртгэл дэх судалгааны төслийн үр дүнгээс шалтгаалан тодорхойгүй хугацаагаар хойшуулсан.

Компани нь эдгээр стандарт болон тайлбаруудыг ирээдүйд дагаж мөрдөх нь Компанийн санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэх эсэхийг нягталж байна.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖ.)

2.3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлж.)

Бүтээгдэхүүний ангилал

Даатгалын гэрээ гэдэг нь Компани (даатгагч) бусдын өмнөөс (даатгуулагч) томоохон хэмжээний даатгалын эрсдлийг хүлээн, хоорондын тохиролцооноос үүдэн мэдэгдээгүй байгаа ирээдүйн үйл явдал (даатгалын тохиолдол) гарсан тохиолдолд нөхөн олговор олгохыг хүлээн зөвшөөрсөн гэрээ юм. Компани нь томоохон даатгалын эрсдлийг тодорхойлохдоо, даатгалын тохиолдол гараагүй үеийн болон даатгалын тохиолдол гарсан үед төлөх төлбөрийг хооронд нь харьцуулж гаргадаг. Даатгалын гэрээгээр санхүүгийн эрсдэлийг мөн шилжүүлж болно.

Томоохон хэмжээний санхүүгийн эрсдэлийг шилжүүлдэг боловч даатгалын эрсдэлийг шилжүүлдэггүй гэрээг хөрөнгө оруулалтын гэрээ гэж үзнэ. Санхүүгийн эрсдэл нь ганц болон бүлэг хүүний түвшин, санхүүгийн хэрэгслийн болон өргөн хэрэглээний барааний үнэ, гадаад валютын ханш, үнийн болон ханшийн, төлбөрийн чадварын тоон үзүүлэлт болон санхүүгийн бус хувьсагч нь гэрээний талтай хамааралгүй байх үед бусад хувьсагчийн үүсч болзошгүй ирээдүйн өөрчлөлтийг илэрхийлнэ.

Даатгалын гэрээ гэж ангилагдсан тохиолдолд тухайн гэрээний эрх, үүрэг нь дууссан ба цуцлагдсанаас бусад тохиолдолд үлдсэн бүх хугацааны турш даатгалын гэрээ гэж тооцогдоно. Хүчин төгөлдөр болсны дараагаар хөрөнгө оруулалтын гэрээний даатгалын эрсдэл нь ихэссэн тохиолдолд даатгалын гэрээгээр ангилагдаж болно

Биет бус хөрөнгө

Тусад нь олж авсан биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь бүртгэдэг. Бизнесийн нэгдлийн үед олж авсан биет бус хөрөнгийн өртөг нь тухайн нэгдэл болсон өдрийн тэдгээрийн бодит үнэ цэнэ байна. Анхлан хүлээн зөвшөөрсний дараа, биет бус хөрөнгийг өртгөөс аливаа нэг хуримтлагдсан хорогдуулалт ба үнэ цэнэ бууралтын алдагдлыг (хэрэв байгаа бол) хассан дүнгээр бүртгэнэ.

Капиталжуулсан хөгжлийн зардлаас бусад дотооддоо бий болгосон биет бус хөрөнгүүдийг капиталжуулахгүй. Үүний оронд холбогдох зардлыг уг зардал гарсан тайлант хугацааны дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа нь хязгаартай эсвэл хязгааргүй эсэхийг үнэлнэ. Компанийн бүх биет бус хөрөнгүүд нь ашиглалтын тодорхой хугацаатай.

Ашиглалтын хязгаарлагдмал хугацаатай биет бус хөрөнгийг эдийн засгийн үр ашигтай хугацааны туршид нь хорогдуулах ба үнэ цэнийн бууралтын шинж тэмдэгүүд илэрсэн үед тухайн биет бус хөрөнгүүд нь үнэ цэнийн бууралтад орсон эсэхийг үнэлж үзнэ. Ашиглалтын хязгаарлагдмал хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулах хугацаа болон аргыг хамгийн багадаа санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үздэг. Хүлээгдэж буй ашиглалтын хугацаа эсвэл хүлээгдэж буй ирээдүйн үр өгөөжийн хэв загварт орсон өөрчлөлтийг хорогдуулалтын хугацаа эсвэл аргын аль тохиромжтойг нь өөрчлөх замаар бүртгэлд тусгах ба уг өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж үзнэ. Хязгаарлагдмал хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулалтын зардлыг дэлгэрэнгүй орлогын тайланд биет бус хөрөнгийн үүрэгтэй нь нийцсэн зардлын бүлэгт хүлээн зөвшөөрнө.

Биет бус хөрөнгийг үл хүлээн зөвшөөрснөөс үүссэн олз эсвэл гарзыг борлуулалтын цэвэр орлого ба бүртгэлийн дүн хоёрын зөрүүгээр хэмжиж хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх үеийн дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖ.)

2.3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлж.)

Биет бус хөрөнгө (үргэлж.)

Компанийн биет бус хөрөнгө нь компьютерийн программ хангамж байна. Компьютерийн программ хангамжийг арван (10) жилийн хугацаанд шулуун шугамын аргыг ашиглан хорогдуулна.

Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Компани нь тайлангийн өдөр бүр хөрөнгө үнэ цэнийн бууралтад орох шинж тэмдэг байгаа эсэхийг үнэлнэ. Хэрвээ шинж тэмдэг илэрвэл эсвэл тухайн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг жил бүр тооцох шаардлагатай бол тухайн хөрөнгийн нөхөн төлөгдөх дүнг тооцно. Хөрөнгө нь бусад хөрөнгө, хөрөнгийн бүлгээс бие даасан, мөнгөн урсгал бий болгохгүйгээс бусад тохиолдолд тухайн хөрөнгийн нөхөн төлөгдөх дүнг хөрөнгийн эсвэл мөнгөн урсгал бий болгож байгаа хэсгийн бодит үнэ цэнээс борлуулалтын зардал ба өнөөгийн ашиглалтын үнэ цэнийг хассан дүнгийн аль ихээр тодорхойлно.

Хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн дансны дүн нь цуглуулан авах дүнгээс илүү байгаа үед хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзэн цуглуулан авах дүн хүртэл нь бууруулж бүртгэнэ. Ашиглалтын үнийг үнэлэхдээ, тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалыг мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ ба хөрөнгөд харгалзах эрсдэлүүдийн талаарх өнөөгийн зах зээлийн үнэлгээнүүдийг тусгасан татварын өмнөх хөнгөлөлтийн хувь хэмжээгээр бууруулан өнөөгийн үнэ цэнийг олно.

Энэ өссөн дүн нь хэрэв өмнөх жилүүдэд хөрөнгөд үнэ цэнийн алдагдлыг хүлээн зөвшөөрөөгүй байсан бол байх ёстой байсан бүртгэлийн цэвэр дүн (элэгдэл/хорогдлыг хассан цэвэр дүн)-гээс хэтрэхгүй байна. Хэрэв тийм бол хөрөнгийн бүртгэлийн дүнг цуглуулан авах дүн хүртэл нь өсгөж бүртгэнэ. Ийм буцаалтыг ашиг эсвэл алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Ийм буцаалтуудыг хийсний дараа, бүртгэлийн шинэчилсэн дүнгээс аливаа үлдэх үнэ цэнийг хассан дүнг хөрөнгийн ашиглалтын үлдэж буй хугацааных нь туршид системтэйгээр хуваарилах үүднээс ирээдүйн тайлант хугацаанд элэгдлийн зардалд залруулга хийнэ.

Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр тооцож тусгана.

Үндсэн хөрөнгийн анхны өртөгт худалдаж авсан үнэ, импортын татвар, татвар болон хөрөнгийг ашиглалтанд оруулахтай холбогдон гарсан зардлууд орно. Ашиглалтанд орсноос хойш гарсан засвар үйлчилгээний зардлуудыг тухайн зардал гарсан жилийн үйл ажиллагааны зардал болгоно. Дараагийн тайлант хугацаанд гарсан зардлыг тухайн зардалтай холбогдсон ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг Компани хүртэх магадлалтай ба өртгийг нь найдвартайгаар хэмжих боломжтой тохиолдолд л хөрөнгийн бүртгэлийн дүн дээр нэмж эсвэл зохистой бол тусдаа хөрөнгөөр хүлээн зөвшөөрдөг.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖ.)

2.3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлж.)

Үндсэн хөрөнгө (үргэлж.)

Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах үед эсвэл түүний ашиглалт, борлуулалтаас ирээдүйд эдийн засгийн үр ашиг хүлээгдэхгүй болсон олсон хөрөнгийг худалдан борлуулах үед эсвэл түүний ашиглалт, борлуулалтаас ирээдүйд эдийн засгийн үр ашиг хүлээгдэхгүй болсон үед үл хүлээн зөвшөөрнө. Үндсэн хөрөнгийн борлуулалтын цэвэр орлого (хэрэв байгаа бол), дансны цэвэр үнэ хоёрын зөрүүг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө. Хөрөнгө тус бүрийн өртгийг үлдэх өртөг хүртэл нь, ойролцоолон тооцоолсон дараах ашиглалтын хугацааны туршид, шулуун шугамын аргаар элэгдүүлнэ. Жилд байгуулах элэгдлийн хувийг дор үзүүлэв. Үүнд:

Ангилал	Years
Тоног төхөөрөмж	10
Тээврийн хэрэгсэл	10
Тавилга, эд хогшил	10
Компьютер, дагалдах тоног төхөөрөмж	3

Тайлант жилийн эцэс бүрт үлдэх өртөг, ашиглалтын хугацаа болон элэгдлийг тохируулж, шалгаж үздэг. Шалгалтын үр дүнг ашиг алдагдалд хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хэрэглүүр

Санхүүгийн хэрэглүүр нь нэг аж ахуйн нэгжийн хувьд санхүүгийн хөрөнгийг, нөгөө аж ахуйн нэгжийн хувьд санхүүгийн өр төлбөрийг эсвэл өмчийн хэрэглүүрийг үүсгэж байдаг аливаа гэрээ юм.

Санхүүгийн хөрөнгө

Анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

бүртгэгдэх, зээл ба авлага, дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт, борлуулахад бэлэн, эсвэл үр ашигтай бол хэджингийн зорилгоорхи үүсмэл хэрэглүүр гэж ангилна. Бүх санхүүгийн хөрөнгүүдийг анхлан хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр нь бүртгэх ба хөрөнгө оруулалтийн бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого зардлаар бүртгэгдэхгүй бол шууд гүйлгээний зардлыг нэмсэн дүнгээр нь хүлээн зөвшөөрнө.

Зах зээлийн зохицуулалт эсвэл журмаар (хэвийн худалдааны нөхцлөөр) тогтоосон хугацааны дотор санхүүгийн хөрөнгийг шилжүүлэх шаардлагатай санхүүгийн хөрөнгийн худалдан авалт эсвэл борлуулалтыг арилжаа хийгдсэн өдөр (энэ нь Компани хөрөнгийг худалдан авах эсвэл борлуулах үүрэг хүлээсэн өдөр юм) хүлээн зөвшөөрнө.

Компаний санхүүгийн хөрөнгөд мөнгө, богино хугацаат хадгаламжууд, худалдааны авлага болон бусад авлагууд орох бөгөөд эдгээр хөрөнгүүд нь бүгд зээл болон авлага доор ангилагдах ба хорогдуулсан өртгөөр тооцогдоно.

Дараах хэмжилт

Зээл болон авлагууд нь идэвхитэй зах зээл дээр бүртгэлгүй, тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөртэй, үүсмэл биш санхүүгийн хөрөнгүүд юм. Анхны хэмжилтийн дараа эдгээр санхүүгийн хөрөнгүүдийн хорогдлын дүнг үр ашигт хүүний арга ашиглан гаргадаг ба түүнээс үнэ цэнийн бууралтыг хасаж өгдөг. Хорогдуулсан өртгийг тооцохдоо худалдан авах үед үзүүлсэн аливаа нэг хөнгөлөлт эсвэл урамшуулал ба үр ашигт хүүний салшгүй хэсэг болсон төлбөр эсвэл зардлыг авч үзнэ.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖ.)

2.3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлж.)

Санхүүгийн хөрөнгө (үргэлж.)

Үл хүлээн зөвшөөрөлт

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг (эсвэл санхүүгийн хөрөнгийг хэсэгчлэн болон хоорондоо төсөөтэй бүлэг санхүүгийн хөрөнгүүдийг хэсэгчлэн) үл хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрх нь дууссан;
- Компани нь тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал авах эрхээ шилжүүлсэн эсвэл "дамжуулан өнгөрөөх" хэлцлийн дагуу хүлээн авсан мөнгөн урсгалыг нийт дүнгээр нь удаан хугацаагаар саатуулалгүйгээр гуравдагч талд өгөх үүрэг хүлээсэн эсвэл; Компани хөрөнгийн дийлэнх эрсдэл болон өгөөжийг шилжүүлсэн буюу Компани тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийг шилжүүлээгүй боловч хөрөнгийн хяналтыг шилжүүлсэн;

Компани нь тухайн хөрөнгөөс мөнгө хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл дамжуулан өнгөрөөх хэлцэл хийсэн боловч хөрөнгөтэй холбоотой ихэнх эрсдэл, өгөөж болон хяналтыг шилжүүлээгүй тохиолдолд хөрөнгийг Компаний уг хөрөнгөд үргэлжлүүлэн оролцсоор байх хэмжээгээр нь хүлээн зөвшөөрнө. Энэ тохиолдолд, Компани нь холбогдох өр төлбөрийг мөн хүлээн зөвшөөрнө. Шилжүүлсэн хөрөнгө ба холбогдох өр төлбөрийг Компаний авч үлдсэн эрх, үүргийг тусган хэмжинэ. Энэхүү үргэлжилсэн оролцоо нь шилжүүлсэн хөрөнгийн баталгаа хэлбэртэй байвал оролцоог тус хөрөнгийн анхны бүртгэлийн дүн Компаний төлөх шаардлагатай болох хамгийн их дүнгийн аль багаар нь хэмжинэ.

Санхүүгийн хөрөнгүүдийн үнэ цэнийн бууралт

Компани нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгүүд нь үнэ цэнийн бууралтад орсныг нотлох бодит нотолгоо байгаа эсэхийг санхүүгийн байдлын тайлангийн өдрөөр үнэлж үзнэ. Хэрэв хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрсний дараа нэг буюу түүнээс олон тооны "Алдагдлын тохиолдол"-ын улмаас үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо бий болсон ба уг "Алдагдлын тохиолдол" нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн бодитойгоор тооцоолох боломжтой ирээдүйн мөнгөн урсгалд нөлөөлж байгаа үед санхүүгийн хөрөнгийг эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзнэ.

Үнэ цэнийн бууралтын нотолгоонд зээлдэгч эсвэл бүлэг зээлдэгчид нь санхүүгийн томоохон хүндрэлд орсон, зээлийн хүү болон үндсэн төлбөр зөрчилд орсон, дампуурал эсвэл санхүүгийн өөр бусад дахин зохион байгуулалтанд орох магадлалтай болсон, зөрчилтэй холбоотой эдийн засгийн нөхцөл байдалд гарсан өөрчлөлт гэх мэт тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд хэмжиж болохуйц бууралт байгааг харуулсан бодит өгөгдөл бий болох зэрэг орно.

Хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгө

Хорогдуулсан өртгөөр нь бүртгэх санхүүгийн хөрөнгүүдийн хувьд Компани эхлээд дангаараа чухал ач холбогдолтой санхүүгийн хөрөнгө тус бүрийн хувьд үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа эсэхийг нэг бүрчлэн (тусгайлан), дараа нь чухал ач холбогдолгүй санхүүгийн хөрөнгүүдийг нийлүүлэн (бүлгээр нь) үнэлнэ. Хэрэв Компани нэг бүрчлэн үнэлэгдсэн санхүүгийн хөрөнгийн үнэлгээний хувьд (чухал ач холбогдолтой, холбогдолгүй эсэхийг үл харгалзан) үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байхгүй гэж үзвэл ойролцоо зээлийн эрсдлийн шинж чанар бүхий санхүүгийн хөрөнгийн бүлэгт оруулан үнэ цэнийн бууралтыг нь нэгдсэн байдлаар үнэлдэг.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖ.)

2.3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлж.)

Санхүүгийн хөрөнгө (үргэлж.)

Үнэ цэнийн бууралтын нэг бүрчлэн үнэлсэн, үнэ цэнийн бууралтын алдагдал нь хүлээн зөвшөөрөгдсөн, эсвэл үргэлжилж буй хөрөнгийг бүлгийн үнэ цэнийн бууралтын үнэлгээнд оруулахгүй.

Үнэ цэнийн бууралтын алдагдлыг тухайн хөрөнгийн бүртгэлийн дүн ба ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн урсгалын өнөөгийнэн, үнэ цэнийн бууралтын алдагдал нь хүлээн хүлээгдэж буй зээлийн алдагдлыг оруулахгүй) зөрүүтээр хэмжинэ. Ойролцоолон тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг санхүүгийн хөрөнгийн анхны, үр ашигт хүүний хувиар бууруулан тооцно.

Хөрөнгийн бүртгэлийн дүнг эрсдлийн сангийн дансаар бууруулах ба алдагдлын дүнг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө. Хүүний орлогыг (ашиг, алдагдалын тайланд санхүүгийн орлого) үлдсэн бүртгэлийн дүнд үргэлжлүүлэн хуримтлуулдаг ба үнэ цэнийн бууралтыг хэмжихийн тулд ирээдүйн мөнгөн урсгалын хөнгөлөлтийг тооцоход ашигласан хүүний хувийг ашиглан хуримтлуулдаг. Цаашид эргэн төлөгдөх ямар нэг бодит чиг хандлага байхгүй байгаа үед зээлийг холбогдох зээлийн эрсдлийн сангийн хамт данснаас хасдаг ба Компани бүх барьцааг хэрэгжүүлэх буюу шилжүүлэн авдаг. Хэрэв дараагийн жил нь үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараах үйл явдлын улмаас тооцоолсон үнэ цэнийн бууралт ихсэх буюу багасах тохиолдолд эрсдлийн санг өөрчлөн тохируулна. Хэрэв данснаас хассан хөрөнгө эргэн төлөгдвөл уг хэмжээгээр ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангийн санхүүгийн өртгийг бууруулж тайлагнана.

Санхүүгийн өр төлбөр

Анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Санхүүгийн өр төлбөрүүдийг аль тохиромжтой байдлаар бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгдэх, зээл ба зээллэг, өглөг, эсвэл үр ашигтай бол хэджингийн зорилгоорхи үүсмэл хэрэглүүр гэж анх хүлээн зөвшөөрөхдөө ангилна. Бүх санхүүгийн өр төлбөрүүдийг анхлан бодит үнэ цэнээр нь, зээл ба даатгалын өглөгийн хувьд шууд хамааралтай гүйлгээний зардалтай цэвэршүүлсэн дүнгээр хүлээн зөвшөөрнө.

Компаний санхүүгийн өр төлбөрүүдэд худалдааны болон бусад өглөгүүд багтах бөгөөд бүх санхүүгийн өр төлбөрүүд нь зээл болон зээллэгэнд ангиллагдана.

Дараах хэмжилт

Анхлан хүлээн зөвшөөрснөөс хойш хураамжын өглөг болон бусад өглөгийг үр ашигт хүүний аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Өр төлбөрүүдийг үл хүлээн зөвшөөрөхөд мөн үр ашигт хүүний аргаар хорогдуулах үйл явцад ашиг, алдагдлыг орлого, зардлаар хүлээн зөвшөөрдөг. Хорогдуулсан өртгийг тооцохдоо үр ашигт хүүний салшгүй хэсэг болох худалдан авалтын урамшуулал, хөнгөлөлт болон шимтгэлийг харгалзан үзнэ. Үр ашигт хүүний аргыг ашиглан хийсэн хорогдуулалтыг ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангийн санхүүгийн зардалд бүртгэнэ.

Үл хүлээн зөвшөөрөлт

Өр төлбөрийн хүлээсэн үүргээс чөлөөлөгдсөн, цуцлагдсан эсхүл хугацаа нь дууссан тохиолдолд санхүүгийн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрнө. Хэрэв одоо байгаа санхүүгийн өр төлбөрийн зээлдүүлэгч нь хэвээрээ боловч ялгаатай нөхцөлтэй зээлийн гэрээгээр сольсон эсвэл одоо байгаа зээлийн нөхцөл эрс өөрчлөгдсөн бол эдгээр өөрчлөлт шинэчлэлтийг анхны санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт ба шинэ өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт гэж үзнэ. Эдгээрийн зөрүүг ашиг, алдагдалын тайланд хүлээн зөвшөөрнө.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖ.)

2.3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлж.)

Санхүүгийн хэрэглүүрүүдийг цэвэршүүлэх

Хэрэв байгууллага нь хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх хуулиар олгогдсон эрхтэй, тооцоог цэвэр дүнгээр нь барагдуулах, эсвэл хөрөнгийг борлуулж өр төлбөрийг нь барагдуулах ажлыг нэгэн зэрэг хийхээр төлөвлөж байгаа тохиолдолд санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрүүдийг хооронд нь цэвэршүүлэн, цэвэр дүнгээр тайлан тэнцэлд толилуулах эрхтэй.

Давхар даатгагчид шилжүүлсэн даатгалын эрсдэл

Компани нь ердийн үйл ажиллагааны хүрээнд даатгалын эрсдлийг давхар даатгагчид шилжүүлдэг. Давхар даатгалын хөрөнгөд давхар даатгагчаас авах авлагын дүн багтана. Давхар даатгагчаас авах авлагын дүнг холбогдох давхар даатгалын гэрээтэй уялдуулан тухайн гэрээний хувьд нэхэмжилсэн хохирлын нөөц болон төлөгдсөн нөхөн төлбөртэй нь ижил аргаар тооцоолно.

Компани нь тайлант хугацаа бүрт, хэрэв тайлант хугацаанд үнэ цэнийн бууралтыг илэрхийлсэн нотолгоо гарсан үед илүү ойр ойрхон давхар даатгалын хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон эсэхд шалгалт хийнэ. Хэрэв давхар даатгалын хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрсний дараа үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо бий болсон ба авлагын дүн бүрэн барагдахгүй байх тохиолдол үүсч уг тохиолдлыг бодитойгоор тооцоолох боломжтой үед давхар даатгалын хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзнэ. Үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг алдагдалд хүлээн зөвшөөрдөг.

Даатгагчдаас шилжсэн даатгалын эрсдэл

Компани нь ердийн үйл ажиллагааны хүрээнд даатгалын компаниудаас даатгалын эрсдлийг мөн шилжүүлэн авдаг. Шилжин ирсэн давхар даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийн зардлыг давхар даатгалын бүтээгдэхүүний ангилалд хамааруулан хүлээн зөвшөөрнө.

Шилжсэн болон шилжүүлсэн даатгалын эрсдлийн үед хураамжийн орлого болон нөхөн төлбөрийг цэвэр дүнгээр хүлээн зөвшөөрнө.

Даатгалын томоохон эрсдлийг шилжүүлэхгүй байгаа давхар даатгалын гэрээнүүд нь санхүүгийн байдлын тайланд шууд тусгагдана. Үүнд хадгаламжийн хөрөнгө болон төлөгдсөн, хүлээн авсан дүнгээс давхар даатгуулагчийн хариуцсан төлбөрийг хассан дүнгээр тооцоолсон санхүүгийн өр төлбөр багтана.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖ.)

2.3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлж.)

Даатгалын авлага

Даатгалын авлага нь даатгалын бүтээгдэхүүн борлуулсан, үйлчилгээ үзүүлснээс үүссэн бусдаас авахаар хүлээн зөвшөөрөгдсөн нэхэмжлэх дүн юм.

Даатгалын хураамжийн авлага нь даатгалын гэрээ байгуулагдсан боловч даатгуулагчаас төлөөгүй байгаа даатгалын хураамж юм. Анхны хэмжилтээс хойш даатгалын авлага нь үр ашигт хүүний аргаар хорогдуулсан өртгөөр хэмжигдэнэ. Даатгалын авлагын дансны үнэ цэнэ ирээдүйд нөхөгдөх боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд тухайн хөрөнгөнд үнэ цэнийн бууралт байгаа эсэхийг шалгаж, үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдалын тайланд бүртгэнэ.

Санхүүгийн хөрөнгийг үл зөвшөөрөх шалгуурыг хангасан үед даатгалын хураамжийн авлагыг үл хүлээн зөвшөөрнө.

Хугацаатай хадгаламж болон үнэт цаас

Хугацаатай хадгаламж нь дотоод болон гадаадын банк санхүүгийн байгууллагад байршуулсан гурван сараас дээш хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификат хамруулна.

Үнэт цаас гэдэг нь өмчийн эрхийг илэрхийлсэн хөрөнгө буюу орлогыг эзэмших эрхийг гэрчилсэн хууль зүйн баримт бичиг юм. Компанийн үнэт цаасд Засгийн Газрын бонд багтана.

Урьдчилж төлсөн зардал

Урьдчилж төлсөн зардал нь хөрөнгө оруулалтын бус зориулалтаар төлсөн мөнгө буюу бэлтгэн нийлүүлэгчид төлсөн боловч ажил, үйлчилгээ, бараагаа харахан аваагүй урьдчилгаа болон урьдчилж төлсөн зардлуудыг хамаарна. Урьдчилж төлсөн зардлыг барааг хүлээн авах мөн үйлчилгээг үзүүлэх үед орлого зарлагын тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө

Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан дах мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь банканд байршуулсан болон гар дээрх бэлэн мөнгө, гурван сар болон түүнээс бага тооны богино хугацаатай хадгаламж орно.

Татвар

Орлогын албан татвар

Компани нь Монгол улсын татварын хууль тогтоомжид заасан татвар ногдох орлогыг нэмэгдүүлэхгүй орлого болон татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлын зүйлсээр залруулсан, санхүүгийн тайлагналын зорилгоор тодорхойлсон өөрийн орлогоос албан татварын хувь хэмжээг тодорхойлдог. Тайлант хугацааны татвар нь тухайн болон өмнөх хугацаанд үүссэн татвар ногдуулах ашиг, алдагдалтай холбоотой татварын байгууллагад төлөх эсвэл түүнээс нөхөн авах дүн болно. Эдгээр дүнг тооцоход ашигласан татварын хувь хэмжээ ба татварын хуулиуд нь тайлант хугацааны эцэст компани үйл ажиллагаагаа явуулж буй Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж байсан.

Өөрийн хөрөнгөд болон бусад дэлгэрэнгүй орлогод шууд хүлээн зөвшөөрөх зүйлсэд ногдох, орлогын албан татварыг, ашиг, алдагдалын тайланд биш өөрийн хөрөнгөд болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

Удирдлага нь НББ-ийг яаж хөтлөхийг холбогдох татварын хууль журмуудад тодорхой зааж өгөөгүй, нэмэлт тайлбар тодруулга шаардлагатай тийм шинэ нөхцөл байдал үүссэн эсэхийг тодруулахаар тодорхой хугацаа тугамд татварын тайлангаа хянаж үздэг ба шаардлагатай бол сан байгуулдаг.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖ.)

2.3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлж.)

Татвар (үргэлж.)

Орлогын албан татварын зардал нь даатгагчаас болон хувьцаа эзэмшигчдээс олсон үр өгөөжид ногдох татвараар шинжигдэнэ. Даатгагчаасаас олсон үр өгөөжид ногдох татвар нь даатгагчтай холбоотойгоор олсон орлого, ашиг болон зардалтай хамааралтай тайлант жилийн болон хойшлогдсон татварын хөдөлгөөнийг илэрхийлнэ.

Хойшлуулсан орлогын албан татвар

Хойшлуулсан орлогын албан татварыг тайлагналын өдрийн байдлаар хөрөнгө, өр төлбөрийн татварын суурь, тэдгээрийн бүртгэлийн дүн хоёрын хоорондох түр зөрүүний дүнгээс өр төлбөрийн аргыг хэрэглэн тооцдог.

- Хэрэв хойшлуулсан орлогын албан татварын өр төлбөр нь гүүдвиллээс эсвэл бизнесийн нэгдлийн үеийн бус гүйлгээнээс үүссэн ба гүйлгээ хийх үед нягтлан бодох бүртгэлийн ашиг ба татвар ногдох ашгийн аль алинд нөлөө үзүүлэхгүй хөрөнгө, өр төлбөрүүдийн анхны хүлээн зөвшөөрөлөөс үүссэн бол; эсвэл
- Охин болон хараат компанид оруулсан хөрөнгө орлуулалт, хамтарсан компани дахь ашиг сонирхолтой холбоотой татвар ногдох түр зөрүүнүүдийн хувьд, үүссэн түр зөрүүг буцаах хугацааг толгой компани, хөрөнгө оруулагч, ашиг хайгч хянаж байгаа бөгөөд түр зөрүү нь ойрын ирээдүйд арилахгүй байх магадлалтай байгаа бол

Дараахаас бусад бүх хасагдах түр зөрүүнүүд, ашиглаагүй татварын хөнгөлөлт, ашиглаагүй татварын алдагдлууд дээр эдгээрийг ашиглаж болох татвар ногдох ашиг олох магадлал байгаа үед хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Хэрэв хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө нь бизнесийн нэгдлийн үеийн бус гүйлгээнээс үүссэн ба гүйлгээ хийгдэх үед нягтлан бодох бүртгэлийн ашиг ба татвар ногдох ашгийн аль алинд нөлөө үзүүлэхгүй хөрөнгө, өр төлбөрүүдийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн бол;
- Охин компанид оруулсан хөрөнгө орлуулалт, хараат компани дахь ашиг сонирхолтой холбоотой татвар ногдох түр зөрүүнүүдийн хувьд, үүссэн түр зөрүү нь ойрын ирээдүйд арилах ба түр зөрүүг ашиглаж болох татвар ногдох ашиг олох магадлал байгаа бол;

Хойшлуулсан татварын хөрөнгийн бүртгэлийн дүнг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр хянаж үздэг ба энэхүү хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн ашиглахад хангалттай хэмжээний татвар ногдох орлого орж ирэх магадлал буурах үед уг бүртгэлийн дүнг бууруулна. Үл зөвшөөрсөн хойшлуулсан татварын хөрөнгийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр дахин үнэлж үздэг ба хойшлуулсан татварын хөрөнгийг ашиглахыг зөвшөөрсөн татвар ногдох орлого ирээдүйд орж ирэх магадлалтай болсон үед хүлээн зөвшөөрнө.

Хөрөнгийг олж авах эсвэл өр төлбөрийг барагдуулах тэр тайлант хугацаанд хэрэглэгдэнэ гэж хүлээж байгаа (тайлант жилийн эцсийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан татварын хувь хэмжээ, татварын хуулиуд дээр үндэслэн) татварын хувь хэмжээгээр хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө, өр төлбөрийг хэмжинэ. Нэг татвар төлөгч, нэг татварын байгууллагад хамаарах хойшлуулсан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлэн тайлагнах хуулиар олгогдсон эрхтэй бол хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь тэнцүүлэн тайлагнаж болно.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖ.)

2.3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлж.)

Түрээс

Тухайн гэрээ нь түрээсийн гэрээ эсвэл түрээс агуулж байгаа эсэхийг тодорхойлохдоо гэрээний агуулга дээр үндэслэх ба гэрээг гүйцэтгэхэд тусгай хөрөнгийг ашиглах шаардлагатай эсэх ба гэрээ нь хөрөнгийг ашиглах эрхийг шилжүүлж байгаа эсэх зэргийг үнэлж үзэх шаардлагатай.

Компани- Түрээслүүлэгчийн хувиар

Түрээс нь анх санхүүгийн эсвэл үйл ажиллагааны түрээсийн ангилалын алинд нь хамаарагдах эсэх нь тодорхойлогдоно. Хөрөнгийн эзэмшилтэй холбоотой бараг бүх эрсдэлийг болон өгөөжийг хүртэхгүй түрээсийг Компани үйл ажиллагааны түрээс гэж ангилна.

Үйл ажиллагааны түрээсийн төлбөрийг түрээсийн хугацаанд шулуун шугамын аргаар бодож ашиг, алдагдал, бусад дэлгэрэнгүй орлогын тайланд зардлаар бүртгэнэ.

Гадаад валютын хөрвүүлэг

Гадаад валютаар гарсан гүйлгээг анх бүртгэхдээ гүйлгээ хийгдсэн өдрийн ханшаар Монгол Төгрөг рүү хөрвүүлж бүртгэнэ. Гадаад валютаар гарсан гүйлгээнүүд нь анх хүлээн зөвшөөрөгдөх өдрийн Компанийн үйл ажиллагааны мөнгөн нэгжид хөрвүүлэгдэж бүртгэгдэнэ.

Гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг санхүүгийн байдлын тайлангийн өдрийн ханшаар (Жишээ нь: Монгол банкны албан ханшаар) дахин хөрвүүлдэг.

Мөнгөн гүйлгээ хийгдэх эсвэл хөрвүүлэх үед гадаад үйл ажиллагааны цэвэр хөрөнгө оруулалтаас үүссэн зөрүүнээс бусад бүх зөрүүг ашиг, алдагдалын тайланд бүртгэнэ. Эдгээр зөрүү нь бусад орлогын дэлгэрэнгүй тайланд цэвэр хөрөнгө оруулалтыг борлуулагдах хүртэл бүртгэгдэх ба борлуулагдсан өдрөөр ашиг, алдагдалын тайланруу дахин ангилагдана. Татварын өөрчлөлт болон эдгээр мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүд дээр үүссэн валютын зөрүүнд хамаарах ашигийг бусад орлогын дэлгэрэнгүй тайланд бүртгэнэ.

Түүхэн өртөг нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг анхны гүйлгээний өдрийн ханшаар хөрвүүлнэ. Бодит үнэ цэнэ нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар хөрвүүлнэ. Мөнгөн бус зүйлсийн дахин хөрвүүлгээс үүссэн олз ба гарз нь тухайн зүйлийн бодит үнэ цэнийн олз, гарзтай адилаар бүртгэгдэнэ (Тухайлбал, бодит үнэ цэнийн олз, гарз нь “Бусад дэлгэрэнгүй орлого эсвэл ашиг, алдагдал”-д бүртгэгдсэн зүйл дээр ханшийн хөрвүүлгээс үүсэх олз, гарз нь мөн адил “Бусад дэлгэрэнгүй орлого эсвэл ашиг, алдагдал”-д тус тус бүртгэгдэнэ.)

2017 оны 12 дугаар сарын 31-нээрх гадаад валютаар илэрхийлэгдсэн балансын үлдэгдэл дүнгүүдийг хөрвүүлсэн албан ёсны ханш 1 ам доллар = 2,427.13 төгрөг (2016 онд: 1 ам доллар = 2,489.53 төгрөг) байв.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖ.)

2.3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлж.)

Давхар даатгалын гэрээний өр төлбөр

Давхар даатгалын гэрээний өр төлбөр нь гэрээ байгуулагдаж, хураамжийн орлого бүртгэгдэх үед хүлээн зөвшөөрөгдөнө. Давхар даатгалын гэрээний өр төлбөрт хамтын эрсдлийн сан, орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан болон эрсдлээс хамгаалах нөөц сан багтана.

Хамтын эрсдлийн сан

Монгол улсын Малын Индексжүүлсэн Даатгалын тухай хуулийн дагуу, малын индексжүүлсэн даатгалын сангийн төрөл нь даатгагчдийн хамтын эрсдэлийн сан ба давхар даатгалын компанийн сангаас бүрдэнэ.

Хамтын эрсдлийн сан нь нэгдүгээр босго үзүүлэлтээс хоёрдугаар босго үзүүлэлт хүртэл хувиар мал хорогдсон хохирлыг нөхөн төлөх үүргийг хамтран хариуцахаар даатгагчдийн хамтарч байгуулсан санг хэлнэ. Энэ санг Компани цуглуулж хариуцаж явах ба хугацаат хадгаламжинд байршуулж, хүүний орлогийг нь даатгагчдын өмнөөс хуримтлуулдаг.

Тайлант жилийн эцсээрх үлдэгдэл нь өр төлбөрөөр бүртгэгддэг ба үйл ажиллагааны бусад орлогын дансанд бүртгэгдсэн хүүний орлогын дүнгээр нэмэгддэг. Хамтын эрсдлийн сангаас нөхөн төлбөр төлөх төлөгдөж үлдсэн хөрөнгийн үлдэгдлийг даатгагчдийн санд оруулсан хөрөнгөд хувь тэнцүүлэн тооцно.

Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан

Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийг тайлагналын өдрөөр даатгалын гэрээний хүчинтэй үлдэх хугацаанд хувь тэнцүүлэн тооцсон даатгалын хураамжийн хэсгүүдийн нийлбэрээр тодорхойлно.

Энэхүү санг даатгалын гэрээ байгуулагдаж даатгалын хураамжийг орлогод хүлээн зөвшөөрөх үед бүртгэх ба хураамжийн орлогыг даатгалын гэрээгээр үзүүлж буй үйлчилгээний хугацаагаар хувь тэнцүүлэн бодно.

Эрсдлээс хамгаалах нөөц сан

Эрсдлээс хамгаалах нөөц сан нь Дунд шатны эрсдлээс хамгаалах сан, Дээд шатны эрсдлээс хамгаалах сан болон Газар тариалангийн даатгалын нөөц сангуудаас бүрдэнэ.

Дунд шатны эрсдлээс хамгаалах сан нь хамтын эрсдлийн сангийн нөөц хүрэлцэхгүй тохиолдолд зарцуулагдана. Жил бүр актуарын тооцооллоор нөөц санг нэмэж байгуулна.

Дээд шатны эрсдлээс хамгаалах сан нь малын хорогдлын хэмжээ дээд түвшний эрсдэлд тооцогдсон үед зарцуулагдана. Жил бүр актуарын тооцооллоор нөөц санг нэмэж байгуулна.

Газар тариалангийн даатгалын нөөц санг Компанийн нийт хураамжийн орлогоос тооцсон хорогдлын харьцаан дээр үндэслэн тооцно. Хорогдлын харьцааг тухайн сумын хорогдлын статистик мэдээллийг ашиглан гаргана.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖ.)

2.3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлж.)

Олон улсын давхар даатгалын өр төлбөр

Олон улсын давхар даатгагчид өгөх өглөг нь олон улсын давхар даатгагчтай байгуулсан давхар даатгалын гэрээтэй холбоотойгоор үүссэн олон улсын давхар даатгагчид төлөхөөр хүлээгдэж буй үүрэг хариуцлага байна. Тухайлбал олон улсын давхар даатгагчид өгөх нөхөн төлбөр, хураамж, шимтгэлийн өглөг хамаарна.

Давхар даатгагчид өгөх хураамжийн өглөг нь давхар даатгагчтай байгуулсан давхар даатгалын гэрээний дагуу давхар даатгагчид төлөх даатгалын хураамж юм.

Давхар даатгагчид өгөх өглөгийг гэрээний хугацаа дуусаж, эрх үүрэг нь хаагдахад мөн даатгалын гэрээг бусдад шилжүүлэх үед үл хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон орлого

Давхар даатгалд шилжүүлсэн даатгалын гэрээнүүдээс олох шимтгэлийн хураамжийн авлагыг даатгалын хураамжийн өглөгийн хугацаанд хойшлуулах ба шулуун шугамын аргаар хорогдуулна.

Сангууд

Компанид өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн өнөөгийн үүрэг (хуулийн эсвэл бүтцийн) байгаа, мөн энэхүү үүргээ биелүүлэхэд эдийн засгийн өгөөж агуулсан баялгийг зарцуулах нь тодорхой болсон ба үүргийн дүнг бодитойгоор ойролцоолон тооцоолох боломжтой үед сан байгуулна. Компани нь байгуулсан сангийн зарим хэсэг болон бүгдийг нөхөн төлбөрөөр эргүүлэн авах тохиолдолд (жишээ нь: даатгалын гэрээтэй), мөн энэхүү нөхөн төлбөр нь гарцаагүй болсон нөхцөлд нөхөн төлбөрийг тусад нь хөрөнгөөр бүртгэнэ. Аливаа сантай холбоотой зардлыг ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд аливаа нөхөн төлбөрийг хассан цэвэр дүнгээр толилуулна.

Мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн үзүүлэх нөлөөлөл материаллаг тохиолдолд сангийн хэмжээг тухайн өр төлбөрт хамаарах эрсдлүүдийг тусгасан, өнөөгийн татварын өмнөх хувь хэмжээг хэрэглэн бууруулна. Бууруулах аргыг хэрэглэж байгаа үед цаг хугацааны улмаас санд гарсан өсөлтийг санхүүгийн зардлаар хүлээн зөвшөөрнө.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖ.)

2.3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлж.)

Эздийн өмч

Энгийн хувьцааг эздийн өмчийн ангилалд оруулна. Энгийн хувьцааны ногдол ашигийг зарласан хугацааны эздийн өмчид хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Өөрийн хөрөнгийн гүйлгээтэй холбоотой гүйлгээний зардлыг татварын дараах дүнгээр нь өөрийн хөрөнгөөс хасна. Өөрийн хөрөнгийн гүйлгээний өртөгт зөвхөн өөрийн хөрөнгийн гүйлгээнд шууд холбоотой гадны нэмэлт зардлууд орно.

Алдагдлаас хамгаалах нөөц сан

Алдагдлаас хамгаалах нөөц сан нь Монголын Засгийн Газрын хөрөнгөөр шууд нэмэгдэж, бусад даатгалын нөөц сангийн хөрөнгө хүрэлцээгүй тохиолдолд зарцуулагдана.

Алдагдлаас хамгаалах нөөц сан нь эздийн өмчийн бүрэлдэхүүн хэсэг боловч Санхүү Зохицуулах Хорооны шаардлагаар давхар даатгалын гэрээний өр төлбөрөөр тайлагнадаг.

Орлого хүлээн зөвшөөрөлт

Нийт хураамжийн орлого

Нийт ердийн даатгалын хураамжийн орлого нь даатгалын компанийн тайлант хугацаанд хийсэн даатгалын гэрээний дагуу даатгуулагчаас авах нийт хураамжийн орлогын дүн байна. Даатгалын хураамжийн орлогыг даатгагчийн хүлээх хариуцлага эхлэх өдрөөр хүлээн зөвшөөрнө. Хураамж нь өмнөх тайлант хугацаанд эхэлсэн даатгалын гэрээнүүдээс энэ тайлант хугацаанд үүсэх залруулгуудыг багтаана. Хураамжийг бүрдүүлж буй хөнгөлөлтүүд нь, жишээлбэл хохиролгүйн шагнал, нийт хураамжийн орлогоос хасагддаг бөгөөд, бусад нь зардлаар хүлээн зөвшөөрөгддөг. Даатгалын тооцоолол болон өнгөрсөн туршлагаас үндэслэн зуучлагчидаас аваагүй хураамжийн орлогыг нийт орлогод оруулж бүртгэнэ

Орлогод тооцоогүй хураамж нь гэрээний эрсдэл нь тайлагналын өдрийн дараа ч үргэлжилж байх хугацаанд ногдох гэрээний хураамжийн хэсэг юм. Орлогод тооцоогүй хураамж нь даатгалын гэрээ тус бүрийн тайлагналын өдрийн дараа ч үргэлжилж байх хугацаанд байгуулагдана. Тайлагналын өдрөөр даатгалын гэрээний хүчинтэй үлдэх хугацаанд хувь тэнцүүлэн тооцсон даатгалын хураамжийн хэсгүүдийн нийлбэрээр орлогод тооцоогүй хураамжруу хойшлогдоно.

Давхар даатгалын хураамж

Давхар даатгалын хураамж гэж давхар даатгалын гэрээний үндсэн дээр даатгагч өөрийн даатгалын эрсдлийг давхар даатгагчид шилжүүлсний төлөө төлөх төлбөр юм. Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөрийг даатгалын зүйлд давхар даатгалын гэрээнд заасан эрсдэл тохиолдож давхар даатгагчаас хохирлыг барагдуулахаар шийдвэрлэсэн үед орлогоор хүлээн зөвшөөрнө. Хэрэв давхар даатгагчаас хохирлыг барагдуулахаар шийдвэрлээгүй боловч давхар даатгагч нөхөн төлбөрийг урьдчилж төлсөн бөгөөд уг төлбөрийг буцаах магадлалгүй бол орлогоор хүлээн зөвшөөрнө

Давхар даатгалын хойшлогдсон хураамж гэдэгт давхар даатгалын хураамжийн давхар даатгалын гэрээний хугацаатай уялдуулан хувь тэнцүүлэх аргаар тооцоолж тайлант хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрөөгүй байгаа хэсгийг ойлгоно.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖ.)

2.3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо

Шимтгэлийн орлого

Даатгалын гэрээ боловсруулахад үзүүлсэн үйлчилгээ, цуцлалт болон бусад гэрээтэй холбоотой гарсан зардыг даатгуулагчид хариуцаж төлнө. Эдгээр төлбөрүүд нь үйлчилгээ үзүүлсэн тайлант хугацаандаа орлогоор хүлээн зөвшөөрөгддөг болно. Хэрэв хүлээн авсан төлбөр нь ирээдүйд үзүүлэх үйлчилгээтэй холбоотой бол дараагийн тайлант хугацаа руу хойшлогдож ирээдүйд хүлээн зөвшөөрөгдөнө.

Хөрөнгө оруулалтын орлого

Хүүний орлогыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан ашиг, алдагдлын тайланд аккруэл сууриар хүлээн зөвшөөрнө. Шимтгэлийн зардал нь санхүүгийн хөрөнгийн үр өгөөжтэй байдлын салшгүй нэг хэсэг бөгөөд санхүүгийн хэрэгслийн үр ашиг хүүний түвшинд хийсэн залруулгаар хүлээн зөвшөөрнө.

Ажиллагсдын тэтгэмж

Богино хугацаат тэтгэмж

Цалин ба түүнтэй холбогдох бусад зардлуудыг Компанийн ажиллагсдын холбогдох үйлчилгээг үзүүлсэн тухайн жилд нь зардалд тусгана. Ажилтнуудад ээлжийн амралт зэрэг богино хугацааны чөлөөтэй үед нөхөн олговрыг ажилласан жилийг нь харгалзан олгодог бөгөөд өвчтэй байх хугацааны нөхөн олговрыг цаг тухайд нь олгодог.

Заавал төлөх даатгалын шимтгэлүүд

Монгол улсын холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа Компаниуд нь Монгол улсын Эрүүл мэнд, нийгмийн даатгалын санд шимтгэл төлдөг. Эдгээр шимтгэлийг гарсан хугацаанд нь ашиг, алдагдал, бусад дэлгэрэнгүй орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

Нөхөн төлбөрийн зардал

Давхар даатгалын нөхөн төлбөрийн зардалд бүх тайлант жилд учирсан нөхөн төлбөрүүд, эдгээртэй холбоотой дотоод болон гадаад нөхөн төлбөрийг барагдуулах үйл явц болон нөхөн төлбөрийг шийдвэрлэхтэй шууд хамааралтай зардлууд, үлдэх өртөг болон бусад буцаан авалтын хасагдуулга, мөн өмнөх жилээс төлөгдөөгүй үлдсэн нөхөн төлбөрүүдийн залруулгууд багтана.

Олон улсын давхар даатгагчид ногдох нөхөн төлбөр

Олон улсын давхар даатгагчид ногдох нөхөн төлбөр нь хамааралтай даатгалын гэрээний нөхцлийн дагуу нийт нөхөн төлбөр хүлээн зөвшөөрөгдөхөд хамт хүлээн зөвшөөрөгдөнө.

Болзошгүй өр төлбөр ба хөрөнгө

Болзошгүй өр төлбөрүүд нь санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрөгдөдгүй бөгөөд санхүүгийн тайлангийн тодруулгад толилуулдаг. Болзошгүй хөрөнгүүд нь санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрөгдөдгүй харин ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг компани хүртэх магадлалтай болсон үед санхүүгийн тайлангийн тодруулгад толилуулдаг.

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ ҮНЭЛЭМЖ, ТООЦООЛОЛ, ТӨСӨӨЛЛҮҮД

Компанийн санхүүгийн тайлангуудыг бэлтгэх ажил нь удирдлагаас тайлагналын өдрийн байдлаар орлого, зардал, хөрөнгө, өр төлбөрийн тайлагнасан дүн ба болзошгүй өр төлбөрийн тодруулга зэрэгт нөлөө үзүүлэх үнэлэмж, ойролцоолсон тооцоолол, төсөөллүүдийг хийхийг шаарддаг. Ойролцоолон тооцоолол болон төсөөллийн тухай тодорхойгүй байдал нь ирээдүйн өр төлбөр эсвэл хөрөнгийн дансны дүнд материаллаг тохирууллага шаардах үр дагаварт хүргэж болно.

Тооцоолол ба төсөөллүүд

Дараагийн санхүүгийн жилд хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн дүнд материаллаг хэмжээний залруулга хийхэд хүргэж болох томоохон эрсдэлтэй, ирээдүйн талаар болон тооцоололд тодорхойгүй байдал үүсгэж буй гол зүйлүүдийн талаар дараах гол төсөөллүүд тайлагналын өдрийн байдлаар байна. Компани нь тооцоолол төсөөллийн параметруудийг Санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэх явцад үндэслэн гаргадаг. Одоогийн санхүүгийн байдал ба ирээдүйн хөгжлийн төсөөлөл нь зах зээлийн өөрчлөлт эсвэл Компаний удирдлагаас үл хамааран өөрчлөгдөж болно. Ийм өөрчлөлтүүд тохиолдсон даруйд төсөөлөл хэсэгт тусгагдана

а. Нөөц сангийн тооцоолол

Малын Индексжүүлсэн Даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу эрсдлийн түвшнийг дараах байдлаар ангилна:

- нэгдүгээр босго үзүүлэлт хүртэл хувиар мал хорогдсон бол эрсдэлийн бага түвшин буюу даатгуулагчийн эрсдэл хүлээх;
- нэгдүгээр босго үзүүлэлтээс хоёрдугаар босго үзүүлэлт хүртэл хувиар мал хорогдсон бол эрсдэлийн дунд түвшин буюу даатгагчийн эрсдэл хүлээх;
- хоёрдугаар босго үзүүлэлтээс дээш хувиар мал хорогдсон бол эрсдэлийн дээд түвшин.

Даатгалын тохиолдлыг тодорхойлох, эрсдэлийг хуваарилах зорилгоор босго үзүүлэлтийг Засгийн газар тогтооно. Засгийн газар босго үзүүлэлтийг шинэчлэн тогтоохдоо нэгдүгээр босго үзүүлэлтийг нэг хувиар, хоёрдугаар босго үзүүлэлтийг тав хүртэл хувиар нэмэгдүүлж, эсхүл бууруулж болно.

Монгол улсын Малын индексжүүлсэн даатгал ("МИД")-ын бүтээгдэхүүн нь сүүлийн 30 гаруй жилийн хугацаанд цуглуулсан малын хорогдлын статистик мэдээлэл дээр үндэслэсэн бөгөөд одоогийн байдлаар МИД-ын хамралтын түвшин нь 1%-аас бага болно. Хамрагдал муутай байдал нь ажиглалтын өрөөсгөл хандлага үүсгэх боломжтой ба хамралтын түвшин цаг хугацаа өнгөрөхийн эрхээр нэмэгдэхэд нөхөн төлбөрийн үйл ажиллагаа мөн/эсвэл шинж чанарт өөрчлөлт гарах эсэх нь тодорхойгүй юм

б. Үндсэн хөрөнгийн элэгдэл

Үндсэн хөрөнгө нь ашиглалтын хугацааныхаа туршид шулуун шугамын аргаар элэгдэнэ. Удирдлага үндсэн хөрөнгийн ашиглагдах хугацааг 3-10 жил гэж тооцоолсон бөгөөд эдгээр нь компаний үйл ажиллагаагаа эрхэлдэг салбарын хувьд нийтлэг хэрэглэгддэг ашиглалтын хугацаа юм.

Хөрөнгийн хүлээгдэж буй хэрэглээний хэмжээний өөрчлөлт болон технологийн шинэчлэл зэрэг нь эдгээр хөрөнгийн үлдэх өртөг болон эдийн засгийн ашиглалтын хугацаанд нөлөө үзүүлж болох тул ирээдүйн элэгдлийн дүн нь өөрчлөгдөж болно.

в. Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Компани нь санхүүгийн бус хөрөнгийн (бараа материал, үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгө) үнэ цэнэ бууралт шаардлагатай эсэхийг үйл явдал эсвэл нөхцөл байдал өөрчлөгдөхөд нөхөн төлөгдөх дүнгээ эргүүлэн олж авч чадах эсэхийг үнэлж үзнэ.

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

4. ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ЦЭВЭР ОРЛОГО

	2017 Мян.төг	2016 Мян.төг
Малын индексжүүлсэн даатгал	1,806,685	981,599
Газар тариалангийн даатгал	44,938	13,014
	<u>1,851,623</u>	<u>994,613</u>

5. ДАВХАР ДААТГАЛЫН ХУРААМЖ

	2017 Мян.төг	2016 Мян.төг
Малын индексжүүлсэн даатгал	(763,361)	(341,809)
Газар тариалангийн даатгал	(37,062)	(11,002)
	<u>(800,423)</u>	<u>(352,811)</u>

6. НӨХӨН ТӨЛБӨРИЙН ЗАРДАЛ

	2017 Мян.төг	2016 Мян.төг
Малын индексжүүлсэн даатгал	—	4,614

7. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЛОГО

	2017 Мян.төг	2016 Мян.төг
Хадгаламжийн хүүний орлого	4,040,115	1,956,205
Засгийн газрын үнэт цаасны хүүний орлого	1,774,047	2,483,026
	<u>5,814,162</u>	<u>4,439,231</u>

8. БУСАД ОРЛОГО БОЛОН АШИГ

	2017 Мян.төг	2016 Мян.төг (дахин толил)
Хамтын эрсдийн сангийн орлого	83,446	68,423
Давхар даатгалын комиссийн орлого	8,339	2,200
Валютын ханшийн хэрэгжээгүй цэвэр ашиг	1,693	—
Шилжсэн үндсэн хөрөнгийн ашиг	233	—
Бусад	8,099	512
	<u>101,810</u>	<u>71,135</u>

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

9. ЕРӨНХИЙ БОЛОН УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

	2017	2016
	Мян.төг	Мян.төг
Цалин хөлс, урамшуулал	1,097,359	1,013,132
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	185,425	10,220
Түрээсийн зардал	138,634	128,477
Албан томилолтын зардал	111,955	93,518
Үндсэн хөрөнгийн элэгдэл (Тод. 12)	86,476	54,610
Борлуулалт, маркетингийн зардал	69,171	60,737
Биет бус хөрөнгийн хорогдуулга (Тод.13)	47,330	694
Бусад	171,882	173,387
	<u>1,908,232</u>	<u>1,534,775</u>

10. БУСАД ЗАРДАЛ БОЛОН ГАРЗ

	2017	2016
	Мян.төг	Мян.төг
		(дахин толил)
Хамтын эрсдлийн сангийн зардал	83,446	68,423
Хандивын зардал	31,178	—
Данснаас хассан үндсэн хөрөнгийн алдагдал (Тод.12)	6,217	—
Валютын ханшийн хэрэгжсэн цэвэр алдагдал	646	392
Бусад	7,540	350
	<u>129,027</u>	<u>69,165</u>

11. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР

Компани нь санхүүгийн тайланд орлогын дүнг орлогын татварын хуульд заасан чөлөөлөгдөх эсвэл үл чөлөөлөгдөх зүйлүүдээр залруулсан дүнг үндэслэн орлогын татварын зардлыг тооцдог. Компани 3 тэрбум (2016 онд 3 тэрбум) төгрөг хүртэл ашгаас 10% (2016 онд 10%) - ийн, 3 тэрбумаас (2016 онд 3 тэрбум) дээш төгрөгийн ашгаас 25% (2016 онд 25%) - ийн орлогын албан татвар төлдөг.

	2017	2016
	Мян.төг	Мян.төг
Тайлант жилийн орлогын албан татвар	<u>404,011</u>	<u>195,621</u>

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

11. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР (ҮРГЭЛЖ.)

Татварын өмнөх ашгаас хуулиар тогтоосон хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардлыг Компанид хүчин төгөлдөр үйлчлэх орлогын татварын хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардалд 2017 оны 12 дугаар сарын 31-ээр хэрхэн тохируулсныг дараах байдлаар үзүүлэв. Үүнд:

	2017	2016
	Мян.төг	Мян.төг
Татварын өмнөх ашиг	<u>4,723,694</u>	<u>3,176,270</u>
25%-ийн орлогын албан татвар (2015: 25%)	1,180,924	794,068
Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлын нөлөө	29,608	5,013
Татвараас чөлөөлөгдөх орлогын нөлөө	(443,512)	(620,756)
Хүлээн зөвшөөрөгдөөгүй хойшлогдсон албан татварын хөрөнгийн нөлөө	97,542	124,291
Ногдох татварын хувь 25%-аас бага хэсгийн нөлөө	<u>(460,551)</u>	<u>(106,995)</u>
Орлогын албан татварын зардал	<u>404,011</u>	<u>195,621</u>

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр, Компаний татварын алдагдалын дүн нь 2,216,632 мян.төг (2015: 1,242,905 мян.төг) ба валютын ханшын хэрэгжээгүй алдагдал нь 1,692,663 төгрөг байсан. Татварын алдагдал болон түр зөрүүг ирээдүйн хоёр санхүүгийн тайлант жилийн татвар ногдох ашигтай цэвэршүүлэх боломжтой. Татвар ногдох орлогыг бууруулах татварын алдагдал нь тухайн жилийн татвар ногдох орлогын 50% хүртэл хязгаарлагддаг.

Компани эдгээр татварын алдагдлыг ашиглахад хүрэлцээтэй татвар ногдох орлого ирээдүйд орж нь тодорхой бус гэж үзсэн учраас хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгө хүлээн зөвшөөгдөөгүй болно.

**ХӨДӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

12. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

	Төног төхөөрөмж	Тээврийн хэрэгсэл	Тавилга эд хогшил	Компьютер, дагалдах хэрэгсэл	Нийт
	Мян.төг	Мян.төг	Мян.төг	Мян.төг	Мян.төг
2017.12.31-ний өдрийн байдлаар					
Өртөг					
2017 оны 1-р сарын 1-нээр	480	619,991	47,255	85,395	753,121
Худалдан авсан	—	—	528	11,008	11,536
Сангийн Яамруу шилжүүлсэн	—	(200,000)	—	—	(200,000)
Данснаас хассан (Тод.10)	—	—	(1,087)	(36,693)	(37,780)
2017.12.31-ний өдрийн байдлаар	480	419,991	46,696	59,710	526,877
Хуримтлагдсан элэгдэл					
2017 оны 1-р сарын 1-нээр	(68)	(78,021)	(6,490)	(29,320)	(113,899)
Тайланг жилд байгуулсан (Тод.9)	(48)	(46,999)	(5,114)	(34,315)	(86,476)
Сангийн Яамруу шилжүүлсэн	—	5,164	—	—	5,164
Данснаас хассан (Тод.10)	—	—	944	30,619	31,563
2017.12.31-ний өдрийн байдлаар	(116)	(119,856)	(10,660)	(33,016)	(163,648)
Дансны гэвэр дүн	364	300,135	36,036	26,694	363,229

2017 оны тайлант жилд, Компани 194,836 мян.төгрөгийн дансны дүнтэй тээврийн хэрэгслийг Сангийн Яамруу шилжүүлсэн.

Уг тээврийн хэрэгслийг 2016 онд 195,069 мян.төгрөгөөр Сангийн Яамнаас шилжүүлэн авсан бөгөөд эздийн өмчийн бусад хэсэгт бүртгэсэн. (Тод.20)

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

12. ҮНДСЭН ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖ)

	Тоног	Тээврийн	Тавилга эд	Компьютер,	Нийт
	төхөөрөмж	хэрэгсэл	хогшил	дагалдах хэрэгсэл	Мян.төг
	Мян.төг	Мян.төг	Мян.төг	Мян.төг	Мян.төг
2016.12.31-ний өдрийн байдлаар					
Өртөг					
2016 оны 1-р сарын 1-нээр	480	320,900	36,009	52,769	410,158
Хуудалдан авсан	—	200,000	3,380	3,149	206,529
Сангийн Яамнаас шилжиж ирсэн	—	99,089	7,866	29,477	136,432
2016.12.31-ний өдрийн байдлаар	480	619,989	47,255	85,395	753,119
Хуримтлагдсан элэгдэл					
2016 оны 1-р сарын 1-нээр	(20)	(45,766)	(2,603)	(10,899)	(59,288)
Тайланг жилд байгуулсан (Тод.9)	(48)	(32,254)	(3,887)	(18,421)	(54,610)
2016 оны 12-р сарын 31-нээр	(68)	(78,020)	(6,490)	(29,320)	(113,898)
Дансны цэвэр дүн	412	541,969	40,765	56,075	639,221

2016 онд Сангийн Яамнаас 136,432 мян.төгрөгийн дүнтэй үндсэн хөрөнгийг шилжүүлсэн. (Тод.20)

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

13. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

	2017	2016
	Мян.төг	Мян.төг
Өртөг		
1-р сарын 1-нээр	468,355	6,930
Нэмэгдсэн	2,970	461,424
12-р сарын 31-нээр	<u>471,325</u>	<u>468,354</u>
Хуримтлагдсан хорогдуулга		
1-р сарын 1-ээр	(695)	—
Тайлант жилийн хорогдуулга (Тод.9)	(47,330)	(694)
12-р сарын 31-ээр	<u>(48,025)</u>	<u>(694)</u>
Дансны цэвэр дүн	<u>423,300</u>	<u>467,660</u>

14. ХАДГАЛАМЖ БА ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС

	2017	2016
	Мян.төг	Мян.төг
Худалдаа Хөгжлийн Банк ХХК	13,050,000	—
Улаанбаатар Хотын Банк ХХК	9,095,590	3,600,000
Хаан Банк ХХК	5,049,170	3,040,000
Капитрон Банк ХХК	4,000,000	2,000,000
Үндэсний Хөрөнгө Оруулалтын банк ХХК	2,250,000	—
Хас Банк ХХК	2,160,865	1,660,030
Капитал Банк ХХК	1,750,017	2,500,000
Төрийн Банк ХХК	1,464,857	1,649,964
Голомт Банк ХХК	302,203	3,439,438
Богд Банк ХХК	50,000	—
	<u>39,172,702</u>	<u>17,889,432</u>
Засгийн газрын үнэт цаас	<u>2,462,701</u>	<u>14,999,930</u>
	<u>41,635,403</u>	<u>32,889,362</u>

Хадгаламж болон засгийн газрын үнэт цаас нь ихэвчлэн 3 сараас 12 сарын хоорондын хугацаатай байдаг ба жилийн хүү нь тус бүр 13.3% - 17.4% ба 9.1% - 16.9%-ийн тогтмол хүү бодогддог. Хүүний орлого нь 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр 5,814,162 мян.төг (2016: 4,439,231 мян.төг) (Тод.7) байна.

Хамтын эрсдлийн санд орж ирсэн мөнгөн хөрөнгийн орлогыг дараах байдлаар шинжилсэн:

	2017	2016
	Мян.төг	Мян.төг
Хамтын эрсдлийн санд орж ирсэн мөнгөн хөрөнгө	<u>1,165,807</u>	<u>846,426</u>

Хамтын эрсдлийн сангийн хөрөнгийг Компаний үйл ажиллагааны зардалд зарцуулахыг тусгай нөхцөлт хадгаламжийн гэрээгээр хааж өгсөн.

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

15. БАРАА МАТЕРИАЛ

	2017 Мян.төг	2016 Мян.төг
Хангамжийн материал	—	8,312

16. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ БА БУСАД АВЛАГА

	2017 Мян.төг	2016 Мян.төг
Засгийн газрын үнэт цаасны хүүний авлага	234,592	341,714
Банкны хадгаламжуудын хүүний авлага	64,001	53,228
Ажилчдаас авах авлага	10,202	3,473
Хувь хүмүүсээс авах авлага	—	5,376
Бусад	—	317,991
	<u>308,795</u>	<u>721,782</u>
Урьдчилгаа	6,802	—
	<u>315,597</u>	<u>721,782</u>

17. ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН АВЛАГА

	2017 Мян.төг	2016 Мян.төг
Малын индексжүүлсэн даатгалын хураамжийн авлага	17,671	128,953
Газар тариалангийн даатгалын хураамжийн авлага	3,050	—
	<u>20,721</u>	<u>128,953</u>

Даатгалын хураамжийн авлага нь хүүгүй ба төлөлтийн нөхцөл нь бүтээгдэхүүн бүрээс шалтгаалж өөр өөр байдаг. Даатгалын хураамжын авлага нь даатгалын гэрээний дүнгээс үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр анх хүлээн зовшоорөгддөг ба энэ дүнгээрээ бүртгэгддэг.

18. МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

	2017 Мян.төг	2016 Мян.төг
Харилцах	430,575	231,260
Бэлэн мөнгө	611	58
	<u>431,186</u>	<u>231,318</u>

19. ЭЗДИЙН ӨМЧ

	Энгийн хувьцааны тоо		Дүн	
	2017	2016	2017 Мян.төг	2016 Мян.төг
Батлагдсан, гаргасан, бүрэн төлөгдсөн	15,000	15,000	15,000,000	15,000,000

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

20. ЭЗДИЙН ӨМЧИЙН БУСАД ХЭСЭГ

	2017 Мян.төг	2016 Мян.төг
1-р сарын 1-ээр	684,333	86,477
Сангийн яамнаас Компанируу шилжиж ирсэн үндсэн хөрөнгө	—	136,432
Сангийн яамнаас Компанируу шилжиж ирсэн биет бус хөрөнгө	—	461,424
Компаниас Сангийн яамруу шилжсэн үндсэн хөрөнгө	(195,069)	—
12-р сарын 31-ээр	<u>489,264</u>	<u>684,333</u>

21. АЛДАГДЛААС ХАМГААЛАХ НӨӨЦ САН

	2017 Мян.төг	2016 Мян.төг
1-р сарын 1-ээр	9,500,000	7,000,000
Хуримтлагдсан ашигаас нэмэгдсэн	2,000,000	—
Бэлэн мөнгөөр орж ирсэн нэмэгдэл	3,500,000	2,500,000
	<u>15,000,000</u>	<u>9,500,000</u>

Бусад нөөц сан шавхагдсан үед алдагдлаас хамгаалах нөөц санг ашиглах зориулалттай. Тайлант жилийн хугацаанд, Сангийн Яам 3,500,000 мян.төгрөгийг хуримтлагдсан ашигаас 2,000,000 мян.төгрөгийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 27-нд гарсан Тушаал дугаар 02/03-ын дагуу нэмсэн.

22. ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ ӨР ТӨЛБӨР

Даатгалын гэрээний өр төлбөрийг дараах байдлаар шинжилсэн:

	2017 Мян.төг			2016 Мян.төг		
	Даатгалын гэрээний хариуцлага	Давхар даатгагчид ногдох хариуцлагын өөрчлөлт	Цэвэр дүн	Даатгалын гэрээний хариуцлага	Давхар даатгагчид ногдох хариуцлагын өөрчлөлт	Цэвэр дүн
Орлогод тооцоогүй нөөц сан	460,217	(205,193)	255,024	1,008,702	(428,089)	580,613
Хамтын эрсдлийн сан	1,165,807	—	1,165,807	846,426	—	846,426
Эрсдлээс хамгаалах нөөц сан	3,270,696	—	3,270,696	3,065,791	—	3,065,791
	<u>4,896,720</u>	<u>(205,193)</u>	<u>4,691,527</u>	<u>4,920,919</u>	<u>(428,089)</u>	<u>4,492,830</u>

Даатгалын орлогод тооцоогүй хураамжийн нөөц нь дараагийн 15 сарын тайлант хугацаанд хорогдохоор хүлээгдэж байна.

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

22. ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ ӨР ТӨЛБӨР (ҮРГЭЛЖ.)

а. Даатгалын гэрээний орлогод тооцоогүй хураамжын нөөцийг дараах байдлаар шинжилсэн:

	2017			2016		
	Даатгалын гэрээний хариуцлага	Мян.төг Давхар даатгагчид ногдох хариуцлагын өөрчлөлт	Цэвэр дүн	Даатгалын гэрээний хариуцлага	Мян.төг Давхар даатгагчид ногдох хариуцлагын өөрчлөлт	Цэвэр дүн
1-р сарын 1-ээр	1,008,702	(428,089)	580,613	—	—	—
Нийт хураамжын орлого	725,611	—	725,611	1,222,415	—	1,222,415
Даатгалын нийт орлогод тооцсон хураамж	(1,274,096)	222,896	(1,051,200)	(213,713)	(428,089)	(641,802)
12-р сарын 31-ээр	460,217	(205,193)	255,024	1,008,702	428,089	580,613

б. Даатгалын компаниудын хамтын эрсдлийн санг дараах байдлаар шинжилсэн:

	2017 Мян.төг	2016 Мян.төг
Хамтын эрсдлийн сан	1,165,807	846,426

Тайлант жилд хамааралтай дунд түвшний эрсдлийг хамтын эрсдлийн сан хариуцдаг ба хамтын эрсдлийн сан нь алдагдлын харьцаан дээр үндэслэн компаний нийт хураамжийн орлогоос тооцоологддог. Алдагдлын харьцааг түүхэн дундаж болон хамгийн өндөр үзүүлэлт буюу боломжит үр дүнгийн 20%-ийг тооцож сонгосон болно.

в. Эрсдлээс хамгаалах сангийн нөөцийг дараах байдлаар шинжилсэн:

	2017 Мян.төг	2016 Мян.төг
Дунд шатны эрсдлээс хамгаалах сан	2,456,083	2,339,627
Дээд шатны эрсдлээс хамгаалах сан	806,763	724,109
Газар тариалангийн даатгалын нөөц сан	7,850	2,055
	3,270,696	3,065,791

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

22. ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ ӨР ТӨЛБӨР (ҮРГЭЛЖ.)

Эрсдлээс хамгаалах сангийн өөрчлөлтийг дараах байдлаар шинжилсэн:

	2017 Мян.төг	2016 Мян.төг
1-р сарын 1-ээр	3,065,791	513,195
Тухай тайлант жилд үүссэн	206,219	367,344
Мөнгөөр орж ирсэн нэмэгдэл	—	2,185,252
Бусад	(1,314)	—
	<u>3,270,696</u>	<u>3,065,791</u>

2016 оны тайлант жилийн хугацаанд, Компаний хувьцаа эзэмшигч мян.төг 2,185,252 мян.төгрөгийн хөрөнгө болон үүнтэй дүйцэхүйц дүнтэй өр төлбөрөөр эздийн өмчийг нэмэгдүүлсэн.

23. ХОЙШЛОГДСОН ОРЛОГО БОЛОН БУСАД ӨГЛӨГ

	2017 Мян.төг	2016 Мян.төг
Хойшлогдсон орлого	847	—
Бусад өглөг	105,103	3,168
	<u>105,950</u>	<u>3,168</u>

Компанийн хойшлогдсон орлого нь 12 сарын хугацаанд төлөгдөхөөр хүлээж байна.

24. ДАВХАР ДААТГАГЧИД ӨГӨХ ӨГЛӨГ

	Давхар даатгагчид өгөх өглөг	
	2017 Мян.төг	2016 Мян.төг
1.31-ний өдрийн байдлаар	—	
Тухай тайлант жилд үүссэн (Тод 5)	800,423	352,811
Төлөгдсөн	(698,425)	(352,811)
12.31-ний өдрийн байдлаар	<u>101,998</u>	<u>—</u>

Дээрх дансны дүнгүүд нь тайлант өдрийн байдлаарх ойролцоо бодит үнэ цэнээр толилуугдсан болно. Даатгалын болон давхар даатгалын үйл ажиллагааны бүх өглөгүүд нь нэг жилийн дотор эргэн төлөгдөхөөр хүлээгдэж байна.

Тайлант хугацааны эцсээрх Компанийн давхар даатгагчидад төлөх өглөгийн насжилтын дүн шинжилгээг үзүүлбэл:

	2017 Мян.төг	2016 Мян.төг
3 сарын хугацаанд	<u>101,998</u>	<u>—</u>

25. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО

Удирдлагын бодлого

Компанийн санхүүгийн эрсдэлийн удирдлагын бодлого нь Компанийн валют, хүүгийн хувь, зээл ба төлбөрийн чадварын эрсдэлүүдийг удирдаж эдгээр эрсдлийн компаний үр дүнд сөргөөр нөлөөлөх боломжит нөлөөг багасгахын зэрэгцээ Компанийн хөгжлийг дэмжих санхүүгийн хүрэлцэхүйц баялагтай байх явдлыг баталгаажуулахыг зорьдог.

Компани нь Төлөөлөн Удирдах Зөвлөл болон түүний дэргэдэх хороод болон удирдлагын хорооноос батлагдсан эрсдэлийн удирдлагын бодлоготой. Энэ бодлого нь Компаний ойлгомжтой бүтэц болон төлөөлөн удирдах зөвлөлөөс эхлээд удирдлагын хороо ба ахлах албан тушаалтнуудын үүрэг болон томилолтыг баримтжуулсанаар дэмжигддэг болно.

Капиталын удирдлага

Компанийн хөрөнгийн удирдлагын үндсэн зорилго нь тасралтгүй үйл ажиллагааг явуулах чадварыг ханган ажиллах, бизнесийн цаашдын үйл ажиллагааг дэмжихийн тулд өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хадгалах болон хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд оршдог.

Компани нь капитал болон өөрийн хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд толилуулсны дагуу удирддаг ба Монголын Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ)-ноос тогтоосон өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хангах үүднээс компанийн капиталыг тодорхой түвшинд хадгалж ажилладаг.

Компани өөрийн хөрөнгийн бүтцийг удирдаж, эдийн засгийн нөхцөл байдал болон үйл ажиллагааных нь эрсдэлийн шинж чанарт орсон өөрчлөлтүүдийг харгалзан капиталын бүтэцдээ залруулга хийдэг байна. Компани капиталынхаа бүтэцээ хадгалах эсвэл тохируулахын тулд хувьцаа эзэмшигчдэд төлөх ногдол ашгийн хэмжээг тохируулах, тэдний хөрөнгийг нь эргүүлэн төлөх эсвэл шинээр энгийн хувьцаа гаргадаг байна. 2016 болон 2017 оны 12-р сарын 31-ний байдлаар компанийн капиталын удирдлагын зорилт болон бодлого, үйл явцад өөрчлөлт гараагүй болно.

Захиргааны удирдлага

Компани нь өөрийн үйл ажиллагаагаа эрхэлж буй эрх зүйн хуул дүрмэнд захирагдана. Энэхүү дүрэм нь зөвхөн зөвшөөрөл олгох болон үйл ажиллагаанд хяналт тавихаас гадна өөр нөхцлүүдээр (жишээлбэл: төлбөрийн чадварын тооцоолол) хязгаарлалт тавьж ажилладаг нь өр төлбөрийн болон татан буугдах эрсдлүүдийг багасгах, даатгалын компаниудыг тооцоолоогүй өр төлбөрүүдээ тухайн үед нь төлөх чадвартай байдлыг хангах зорилготой болно.

Санхүүгийн чадал, өөрийн өмч, төлбөрийн чадварыг тайлагнахдаа СЗХ-оос баталсан дүрмийн дагуу тооцоолно. Эдгээр хөрөнгийн шалгуурууд нь байх ёстой төлбөрийн чадвар, өмч болон бизнесийн онцлогийг тусгасан зохистой үнэлэмжүүд дээр үндэслэгддэг болно.

Компаний даатгалын бизнесдээ баримталдаг капиталын удирдлагын бодлого нь СЗХ-ны тогтоол дээр үндэслэн заавал байлгах ёстой болон бусад нэмэлтээр шаардлагатай хөрөнгийг эзэмших явдал юм.

2017 болон 2016 оны тайлант жилийн хугацаанд Компани эдгээр бүх шалгууруудыг давсан болно.

26. ДААТГАЛЫН БОЛОН САНХҮҮГИЙН ЭРСДЭЛ

Даатгалын үйл ажиллагааны эрсдэл

Даатгалын үйл ажиллагааны эрсдэл гэж аль нэг даатгалын гэрээ хийгдсэнтэй холбоотойгоор урган гарч болох тухайн даатгуулсан үйл явдал болон нөхцөл байдлыг ойлгох ба үүнээс болж тодорхой бус хэмжээний алдагдал хүлээн зөвшөөрөх боломжтой эрсдэлийг хэлнэ. Даатгалын гэрээний үндсэн мөн чанар нь тухайн эрсдэл тохиолдлын шинжтэй тул урьдчилан таамаглах боломжгүй юм.

Компанид даатгалын гэрээнүүдийн улмаас тулгарч буй гол эрсдэл нь төлөгдсөн нөхөн төлбөр болон цаг хугацааны хувьд тооцоолсноос зөрөх явдал юм. Энэ эрсдэл нь нөхөн төлбөрийн давтамж, ноцтой байдал, төлсөн төлбөр ба урт хугацаат нөхөн төлбөрийн нэмэлт хөгжлөөс хамааралтай байдаг. Тиймээс, Компаний зорилго нь эдгээр өр төлбөрүүдийг барагдуулах хангалттай санг байлгах юм.

Малын индексжүүлсэн даатгалтай холбоотойгоор урган гарч болох болзошгүй томоохон нөхөн төлбөрүүд нь Компанийн мөнгөн гүйлгээ болон үр дүнгийн үзүүлэлтүүдэд бодитой нөлөө үзүүлж чадахуйц гол хүчин зүйл юм. Түүнчлэн Компанийн бизнесийн үйл ажиллагаа нь зөвхөн Монголд төвлөрдөг. Энэ нь Компанийн даатгалын багц дах эрсдэлүүд нь газар зүйн хувьд нэг байршилд төвлөрсөн байгааг харуулж байна. Үүнээс үндэслэн өнгөрсөн дэх адил төстэй эрсдэлүүдээс үүссэн нөхцөл байдал болон түүхэн алдагдлын давтамж дээр суурилсан даатгалын эрсдэлийн төвлөрөлийг зохицуулах оновчтой болоод зохистой давхар даатгалын хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор Компани нь давхар даатгалын хамгаалалтын менежментийн бодлогыг сонгон авч ажиллаж байна.

Компанийн давхар даатгалын хамгаалалтын менежментийн бодлогын зорилгод хувьцаа эзэмшигчдийн өмчийг хамгаалах, Компанийн даатгалын үйл ажиллагааны үр дүнгээс үүсэж болох тогтворгүй байдлыг намжаах, Компанид өрсөлдхүйц давуу тал бий болгох, тогтвортой болоод олон талт давхар даатгалын баталгааг санал болгох болон урт хугацааны стратегийн түншлэлийг гол давхар даатгагчидтай бэхжүүлэн хөгжүүлэх зэрэг зүйлс багтдаг. Тайлант хугацааны эцэс бүрт удирдлага давхар даатгагчдад төлбөрийн чадварын үнэлгээ хийж давхар даатгалын худалдан авалтын стратегийг шинчлэн боловсруулдаг ба үүгээрээ давхар даатгалын хөрөнгө дэх үнэ цэнийн бууралтыг тогтоох боломжтой

Давхар даатгагчаас нөхөн төлөгдөх дүн нь төлөгдөөгүй байгаа нөхөн төлбөрийн сантай адил аргаар давхар даатгалын гэрээнүүдийн дагуу тооцоологдоно. Давхар даатгалд хамрагдсанаараа Компани нь даатгуулагчиддаа хүлээсэн шууд үүргээсээ чөлөөлөгдөхгүй учраас давхар даатгалд хамаарагдсан даатгалуудын хувьд төлбөрийн чадварын эрсдэл нь давхар даатгагч нь гэрээнийхээ үүргийг биелүүлэх чадвараар хязгаарлагдана. Компани зөвхөн нэг давхар даатгагчаас хамааралгүй ба мөн зөвхөн нэг давхар даатгалын гэрээнээс ихээхэн хамааралтай биш байдлаар давхар даатгалаа хуваарилсан болно.

Урт хугацааны бус даатгалын гэрээнүүд

Компани дараах төрлүүдийн ердийн даатгалын гэрээг олгодог болно, үүнд: малын индексжүүлсэн болон газар тариалангийн даатгал орно. Урт хугацааны бус даатгалууд нь ихэнхдээ 15 сарын хугацаанд эрсдлийг даатгадаг.

Эдгээр даатгалын гэрээнүүдийн хамгийн том эрсдлүүд дотор үер, зуд гэх мэт байгалийн гамшигууд болон малын хулгай ба чонод идүүлэх гэх мэт урьдчилан таамаглах боломжгүй эрсдлүүд ордог.

26. ДААТГАЛЫН БОЛОН САНХҮҮГИЙН ЭРСДЭЛ (ҮРГЭЛЖ.)

Даатгалын үйл ажиллагааны эрсдэл

Гол төсөөллүүд

Өр төлбөрийн тооцооллын үндсийг бүрдүүлж буй гол төсөөллүүд нь Компаний ирээдүйн нөхөн төлбөрүүд нь өмнөх жилүүдтэйгээ ижил хэлбэрээр үүсэхэд тулгуурлана. Үүнд, дундаж нөхөн төлбөр, түүнтэй холбогдон гарах зардал, нөхөн төлбөртэй холбоотой имфляцийн нөлөө болон тохиолдлын жилд гарсан нөхөн төлбөрийн тоо хэмжээ ордог.

Нэмэлтээр тоон бус үнэлэмжүүд нь аль өмнөх жилийн хандлага нь ирээдүйд хамааралгүйг дүгнэнэ, жишээлбэл: зөвхөн нэг удаагийн тохиолдлууд, олон нийтийн нөхөн төлбөрийг харах хандлага, эдийн засгийн байдал гэх мэт зах зээлийн хүчин зүйлүүдээс гадна дотоод хүчин зүйлүүд болох бүтээгдэхүүний төрлүүд, журмын нөхцлүүд ба нөхөн төлбөрийн үйл ажиллагаанууд орно. Энэхүү үнэлэмж нь гаднаас ирж буй нөлөөлөл болох шүүхийн шийдвэр болон засгийн газраас гаргасан хууль нь хэрхэн тооцоололд өөрчлөлт оруулахыг мөн шалгана.

Мэдрэмж

Урт хугацааны бус даатгалын нөхөн төлбөрийн өглөг нь доорх хүснэгтэд үзүүлсэн гол төсөөллүүдээс мэдрэмтгий хуулийн өөрчлөлт болон тодорхой бус байдал гэх мэт төсөөллүүдийн мэдрэмжийг бөгөөд тооцоолох боломжгүй байдаг.

Гол төсөөллүүдээс бусад бүх төсөөллүүд нь тогтмол гэж үзвэл, гол төсөөлөлд гарах боломжтой өөрчлөлтүүд нь нийт болон цэвэр өр төлбөр, татвараас өмнөх ашиг болон өөрийн хөрөнгөд хэрхэн нөлөөлхийг доорх хүснэгт үзүүлнэ. Төсөөллүүдийн хоорондын уялдаа нь эцсийн нөхөн төлбөрийн өглөгийг тооцоолоход томоохон нөлөөлөл үзүүлэх боловч, төсөөллийн өөрчлөлтийн нөлөөллийг үзүүлэхийн тулд, тус бүрт нь өөрчлөх шаардалагатай. Эдгээр төсөөллүүдийн өөрчлөлт нь шугаман бусаар өөрчлөгдөж байгаа болно. Төсөөллүүдийн мэдрэмж нь эдийн засгийн өнөөгийн үзүүлэлтүүд, ихэвчлэн опцион болон баталгааны уламжлалт өртөг болон цаг хугацааны үнэ цэнийн өөрчлөлтийн нөлөөллөөс хамаарна.

Мэдрэмжийн дүн шинжилгээг хийхэд давхар даатгалд ногдох бүх нөхөн төлбөрүүд нь буцаан олгогдохоор төсөөлөгдсөн. Ялангуяа нөхөн төлбөрийн нөөц 10% -аар өссөн гэж тооцвол гэрээгээр тохиролцсон давхар даатгагчид ногдох нөхөн төлбөрч мөн адил тухайн өссөн дүнгээр нэмэгдэн буцаан олгогдохоор төсөөлөгдсөн болно.

2017.12.31-ний өдрийн байдлаар	Дундаж нөхөн төлбөрийн зардалын төсөөллийн өөрчлөлт	Нийт өр төлбөрийн өсөлт/ (бууралт)	Цэвэр дүнгээрх өр төлбөрийн өсөлт/ (бууралт)	Татварын өмнөх ашигийн өсөлт/ (бууралт)	Өөрийн хөрөнгийн* өсөлт/ (бууралт)
		MNT'000	MNT'000	MNT'000	MNT'000
Мэдрэмж	+10%	489,672	469,153	(469,153)	(422,238)
	-10%	(489,672)	(469,153)	469,153	422,238
2017.12.31-ний өдрийн байдлаар	Дундаж нөхөн төлбөрийн зардалын төсөөллийн өөрчлөлт	Нийт өр төлбөрийн өсөлт/ (бууралт)	Цэвэр дүнгээрх өр төлбөрийн өсөлт/ (бууралт)	Татварын өмнөх ашигийн өсөлт/ (бууралт)	Өөрийн хөрөнгийн* өсөлт/ (бууралт)
		MNT'000	MNT'000	MNT'000	MNT'000
Мэдрэмж	+10%	492,092	449,283	(449,283)	(404,355)
	-10%	(492,092)	(449,283)	449,283	404,355

* Өөрийн хөрөнгөд үзүүлэх нөлөөг харуулахдаа татварын нөлөөллийг оролцуулан тооцсон.

26. ДААТГАЛЫН БОЛОН САНХҮҮГИЙН ЭРСДЭЛ (ҮРГЭЛЖ.)

Санхүүгийн эрсдлүүд

Компаний гол санхүүгийн хэрэгслүүд нь үйл ажиллагааны авлага, урьдчилж гарсан зардал, мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, богино хугацаат хадгаламж, давхар даатгагчид өгөх өглөг болон бусад өглөгүүдээс бүрдэнэ.

Компаний эдгээр санхүүгийн хэрэгслүүдээс үүсч буй гол эрсдлүүд нь төлбөрийн чадварын, хүүний түвшний, хөрвөх чадварын болон гадаад валютын эрсдэл юм. Компанийн удирдлагын эрсдэлүүдэд тавидаг хяналтууд болон баталсан бодлогуудын доор нэгтгэн үзүүлэв.

Төлбөрийн чадварын эрсдэл

Төлбөрийн чадварын эрсдэл гэдэг нь нэг тал санхүүгийн хэрэглүүрт хамаатай үүрэг хариуцлагаа нөгөө талд шилжүүлж чадахгүй болсноос болж нөгөө тал санхүүгийн алдагдал хүлээх эрсдэл юм. Компани голдуу банкин дах мөнгө, хугацаат хадгаламж, даатгуулагчдаас авах даатгалын хураамжын авлагууд болон давхар даатгагчдаас авах авлагуудаас төлбөрийн чадварын эрсдэлд өртөх боломжтой.

Компани нь төлөөлөн удирдах зөвлөл болон удирдлагын зүгээс зах зээл дээр эзлэх байр суурь болон төлбөрийн чадвар сайн гэж үнэлэгдсэн банкуудад мөнгөн хөрөнгүүдээ байршуулдаг. Үүнтэй адил Компани нь зөвхөн удирдагаар үнэлэгдсэн хангалттай төлбөрийн чадвар болон нэр хүндтэй давхар даатгалын компаниудтай хамтарч ажилладаг.

Хөрвөх чадварын эрсдэл

Хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь Компани санхүүгийн өр төлбөрөө барагдуулахтай холбоотойгоор үүсэн гарах эрсдэл юм. Компанийн удирдлага нь энэхүү эрсдлийг зохицуулахын тулд бодиг болон төлөвлөгөөт мөнгөн урсгалыг тодорхой цаг тутамд хянаж хөрөнгө оруулалтын зохих ёсны дүнг мөнгөн урсгалын хэрэгцээт шаардлагыг хангаж байхаар богино хугацаанд хөрвөх чадвартай хөрөнгө хэлбэрт байлгадаг юм.

Компани нь үндсэн болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаагаа дан ганц үйл ажиллагаанаас орж ирсэн мөнгөн гүйлгээгээр санхүүжүүлдэг. Компани нь даатгауулагчдаас нэхэмжлэх нөхөн төлбөрүүдийг барагдуулахын тулд өдөр тутам бэлэн мөнгөний хэрэгцээт шаардлагатай тулгарч байдаг. Компанийн удирдлага 2017 оны 12 сарын 31-ны байдлаарх компанийн богино хугацаанд хөрвөх чадвартай хөрөнгүүд нь ихэнхдээ бэлэн мөнгө болон банкин дах хадгаламж хэлбэрт байгааг харгалзан, дээрх өдрийн байдлаарх дуусах хугацааны профиль нь ямар нэг томоохон хөрвөх чадварын эрсдэлд оруулна гэж бодохгүй байна.

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

26. ДААТГАЛЫН БОЛОН САНХҮҮГИЙН ЭРСДЭЛ (ҮРГЭЛЖ.)

Дараах хүснэгтэнд санхүүгийн тайлангийн хугацааны эцсээрх Компанийн санхүүгийн хөрөгө болон өр төлбөрүүдийн гэрээний бууруулаагүй дүнг дуусгавар хугацаагаар нь ангилан харуулав.

	Хугацаагүй Мян.төг	3 сар хүртэл Мян.төг	3 сараас дээш Мян.төг	Нийт Мян.төг
2017.12.31-ний өдрийн байдлаар				
Санхүүгийн хөрөнгө				
- Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	431,186	—	—	431,186
- Хадгаламж, үнэт цаас	—	—	41,635,403	41,635,403
Даатгалын хураамжийн авлага	20,721	—	—	20,721
- Бусад авлага	10,202	53,190	245,403	308,795
	<u>462,109</u>	<u>53,190</u>	<u>41,880,806</u>	<u>42,396,105</u>
Санхүүгийн өр төлбөр				
-Бусад өглөг	—	105,103	—	105,103
Давхар даатгагчид өгөх өглөг	—	101,998	—	101,998
	<u>—</u>	<u>207,101</u>	<u>—</u>	<u>207,101</u>
	Хугацаагүй Мян.төг	3 сар хүртэл Мян.төг	3 сараас дээш Мян.төг	Нийт Мян.төг
2016.12.31-ний өдрийн байдлаар				
Санхүүгийн хөрөнгө				
- Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	231,318	—	—	231,318
Хадгаламж, үнэт цаас	—	—	32,889,362	32,889,362
Даатгалын хураамжийн авлага	128,953	—	—	128,953
- Бусад авлага	3,473	323,367	394,942	721,782
	<u>363,744</u>	<u>323,367</u>	<u>33,284,304</u>	<u>33,971,415</u>
Санхүүгийн өр төлбөр				
Бусад өглөг	87	2,731	—	2,818
	<u>87</u>	<u>2,731</u>	<u>—</u>	<u>2,818</u>

Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн эрсдэл гэдэг нь зах зээлийн үнийн өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэгслүүдийн үнэ цэнэ эсвэл ирээдүйн мөнгөн урсгал хэлбэлзэх эрсдэлийг хэлнэ. Зах зээлийн эрсдэл нь гурван төрлийн эрсдэлээс бүрдэнэ: гадаад валютын эрсдэл, хүүний түвшний эрсдэл болон зах зээлийн үнийн эрсдэл.

26. ДААТГАЛЫН БОЛОН САНХҮҮГИЙН ЭРСДЭЛ (ҮРГЭЛЖ.)

I. Гадаад валютын эрсдэл

Гадаад валютын эрсдэл гэдэг нь санхүүгийн хэрэглүүрийн үнэ цэнэ гадаад валютын ханшийн сөрөг өөрчлөлтийн улмаас хэлбэлзэх эрсдэл юм. Компанийн гадаад валютын эрсдэл нь ихэвчлэн гадаадын давхар даатгалын компаниудаас хүлээн авсан мөнгө болон төлсөн төлбөрүүдээс учирдаг. Мөн Компанийн гадаад валютын эрсдэл нь гадаад валютаар илэрхийлэгдсэн (ихэвчлэн ам.доллар) банкинд дах мөнгөн хадгаламж болон бусад өглөгүүдээс үүсдэг. Даатгалын хураамжийн орлогын гүйлгээнүүд нь үйл ажиллагааны мөнгөн нэгж (төгрөг)-р хийгддэг учраас даатгалын үйл ажиллагаанаанаас үүдэн гарах гадаад валютын эрсдэлийн нөлөө бага юм.

Компанид гадаад валютын эрсдлийг зохицуулах албан ёсны бодлого болон журам байдаггүй учир нь гэвэл Компанийн удирдлага гадаад валютаар хийгдэх гүйлгээнүүд харьцангуй бага байдагтай холбоотойгоор энэ эрсдлээс үүсэх нөлөө материаллаг бус гэж үздэг.

Өөр бусад бүх хувьсагчид тогтмол байхаар тооцвол, тайлант жилийн эцсээрх гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс Компанийн үйл ажиллагааны мөнгөн нэгжид үзүүлэх нөлөөлөл ашиг, алдагдал болон өөрийн хөрөнгөд хэрхэн нөлөөлөх талаар дараах хүснэгтэд үзүүлсэн.

	2017	2016
	Мян.төг	Мян.төг
+5% (2016: +5%) (Ам.доллар)	(5,089)	131
— 5% (2016: —5%) (Ам.доллар)	5,089	(131)

II. Хүүний түвшний эрсдэл

Хүүгийн түвшний эрсдэл нь зах зээлийн хүүгийн түвшний өөрчлөлт санхүүгийн хэрэглүүрийн ирээдүйн мөнгөн урсгал эсвэл санхүүгийн байдлын тайлан дах бодит үнэ цэнэд нөлөөлж болох эрсдэл юм.

Компанид хүүний түвшний эрсдлийг зохицуулах албан ёсны бодлого болон журам байдаггүй учир нь гэвэл Компанийн удирдлага нь ихэнх хүү бодогддог хөрөнгүүд (банкн дах хугацаат хадгаламжууд) нь тогтмол хүүтэй байдаггч харгалзан энэ эрсдлээс компанийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөө материаллаг бус гэж үздэг. 2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31 -ны байдлаар Компанид хүү бодогддог өр төлбөрүүд байхгүй байна.

27. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР БА АМЛАЛТ

Хуулийн зарга болон дүрэм

Даатгалын салбарт үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд нь хуулийн заргад дуудагдах нь бизнесийн хэвийн үйл ажиллагааны нэг хэсэг юм. Бүх шүүх ажиллагаа явагдаж байгаа болон шүүхэд хандахаар зэхэж буй маргаануудын эцсийн шийдвэрийг тооцоолох боломжгүй ч, компаний удирдлага эдгээр заргууд нь (шүүхээр шийдэгдэх маргаануудыг оруулна) санхүүгийн байдал болон үр дүнд материаллаг нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна.

Компани нь мөн төлбөрийн чадвар нь зохих түвшинд хангагдсан эсэхийг тогтоох журмын дагуу бүх нөхцөлүүдэд нийцсэн байх ёстой. Энэ журмын дагуу нийцтэй болон зөрчилтэй ажилснаас үүсэлтэй болзошгүй өр төлбөр Компанид байхгүй болно.

28. ХОЛБООТОЙ ТАЛУУДТАЙ ХИЙСЭН ГҮЙЛГЭЭНҮҮД

Гол удирдах албан тушаалтнуудад олгосон цалин, урамшуулал

Компаний гол удирдах албан тушаалтнуудад удирдлагын эрх бүхий албан тушаалтнууд багтана. Доорх хүснэгтэд тодруулсан дүнгүүд нь тайлант хугацаанд удирдах албан тушаалтнуудад хамааралтайгаар зарлагад бүртгэгдсэн болно.

	2017	2016
	Мян.төг	Мян.төг
Цалин	118,470	100,722
Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл	13,032	11,079
	<u>131,502</u>	<u>111,801</u>

Сангийн яам болон компаний хооронд шилжигдсэн хөрөнгүүдийг доорх хүснэгтээр үзүүлэв

	2017	2016
	Мян.төг	Мян.төг
Сангийн яамнаас Компанируу шилжиж ирсэн үндсэн хөрөнгө	—	136,432
Сангийн яамнаас Компанируу шилжиж ирсэн биет бус хөрөнгө	—	461,424
Компаниас Сангийн яамруу шилжсэн үндсэн хөрөнгө	(195,069)	—
	<u>131,502</u>	<u>111,801</u>

29. ӨМНӨХ ТАЙЛАНТ ЖИЛИЙН ДҮНГҮҮДИЙН ДАХИН ТОЛИЛУУЛАЛТ

2016 болон 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар үлдэгдэлүүд нь 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нягтлан бодохын журамын дагуу толилуулсан үлдэгдэлүүдтэй харьцуулагдахад тохиромжтой байдлаар залруулагдсан болно.

- а. Хамтын эрсдэлийн сангаас олсон хүүгийн орлого болон зардалыг ижил дүнгээр ашиг алдагдалын тайланд толилуулсан
- б. Тайлагналын өдрөөрх тасалбар болгож бүртгэгдэх байсан хураамжийн орлогын дүн болон урьдчилж төлсөн зардалаар бүртгэгдсэн байсан давхар даатгалын хойшлогдсон хураамжаас үүдэн хуримтлагдсан ашгийн дүнг бууруулсан

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

29. ӨМНӨХ ТАЙЛАНТ ЖИЛИЙН ДҮНГҮҮДИЙН ДАХИН ТОЛИЛУУЛАЛТ (ҮРГЭЛЖ.)

	Өмнөх тайлагналаар Мян.төг	Залруулгууд Мян.төг	Дахин толилуулалт Мян.төг
2016.12.31-ний өдрийн байдлаар			
<i>Санхүүгийн байдлын тайлан</i>			
Хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	639,221	—	639,221
Биет бус хөрөнгө	467,660	—	467,660
Хадгаламж, үнэт цаас	32,889,362	—	32,889,362
Давхар даатгагчийн хойшлогдсон хураамж	428,089	—	428,089
Бараа материал	8,312	—	8,312
Урьдчилж төлсөн зардал болон бусад авлага	721,782	—	721,782
Даатгалын хураамжийн авлага	128,953	—	128,953
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	231,318	—	231,318
	<u>35,514,697</u>	<u>—</u>	<u>35,514,697</u>
Эздийн өмч болон өр төлбөр			
Даатгалын өглөг	—	—	—
Урьдчилж олсон орлого болон бусад өглөг	б 2,818	350	3,168
ААНОАТатварын өглөг	21,519	—	21,519
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан	1,008,702	—	1,008,702
Хамтын эрсдлийн сан	846,426	—	846,426
Алдагдлаас хамгаалах сан	9,500,000	—	9,500,000
Эрсдлээс хамгаалах сан	3,065,791	—	3,065,791
Эзэмшигчдийн өмч	15,000,000	—	15,000,000
Эздийн өмчийн бусад хэсэг	684,333	—	684,333
Хуримтлагдсан ашиг	б 5,385,108	(350)	5,384,758
	<u>35,514,697</u>	<u>—</u>	<u>35,514,697</u>
	Өмнөх тайлагналаар Мян.төг	Залруулгууд Мян.төг	Дахин толилуулалт Мян.төг
2016.12.31-ний өдрийн байдлаар			
<i>Ашиг алдагдал болон дэлгэрэнгүй орлогын тайлан</i>			
Даатгалын цэвэр хураамжийн орлого	641,802	—	641,802
Нөхөн төлбөрийн цэвэр зардал	(371,958)	—	(371,958)
Хөрөнгө оруулалтын орлого	4,439,231	—	4,439,231
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	а 2,712	68,423	71,135
Үйл ажиллагаа, ерөнхий удирдлагын зардал	(1,534,775)	—	(1,534,775)
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	а (742)	(68,423)	(69,165)
Орлогын татварын зардал	(195,621)	—	(195,621)
	<u>2,980,649</u>	<u>—</u>	<u>2,980,649</u>

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

29. ӨМНӨХ ТАЙЛАНТ ЖИЛИЙН ДҮНГҮҮДИЙН ДАХИН ТОЛИЛУУЛАЛТ (ҮРГЭЛЖ.)

	Өмнөх тайлагналаар Мян.төг	Залруулгууд Мян.төг	Дахин толилуулалт Мян.төг
2015.12.31-ний өдрийн байдлаар			
<i>Санхүүгийн байдлын тайлан</i>			
Хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	350,869	—	350,869
Биет бус хөрөнгө	6,930	—	6,930
Хадгаламж, үнэт цаас	16,997,271	—	16,997,271
Бараа материал	3,133	—	3,133
Урьдчилж төлсөн зардал болон бусад авлага	379,123	212,603	591,726
Даатгалын хураамжийн авлага	156,007	—	156,007
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	8,509,843	—	8,509,843
	<u>26,403,176</u>	<u>212,603</u>	<u>26,615,779</u>
Эздийн өмч болон өр төлбөр			
Эзэмшигчдийн өмч	15,000,000	—	15,000,000
Эздийн өмчийн бусад хэсэг	86,477	—	86,477
Хуримтлагдсан ашиг	3,151,300	(747,191)	2,404,109
Урьдчилж олсон орлого болон бусад өглөг	1	981,599	981,600
ААНОАТатварын өглөг	39,341	—	39,341
Хамтын эрсдлийн сан	591,057	—	591,057
Алдагдлаас хамгаалах сан	7,000,000	—	7,000,000
Эрсдлээс хамгаалах сан	535,000	—	535,000
	<u>26,403,176</u>	<u>212,603</u>	<u>26,615,779</u>

30. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮРҮҮДИЙН БОДИТ ҮНЭ ЦЭНЭ

Бодит үнэ цэнэ гэдэг нь хэмжилтийн өдрөөр зах зээлийн оролцогчидын хооронд хийгдэх хөрөнгийн борлуулалт эсвэл өр төлбөр төлөхөөр хийгдсэн ердийн гүйлгээний үнэ юм.

Бодит үнэ цэнийг бүхэлд нь хэмжихэд ач холбогдолтой хамгийн доод түвшингийн өгөгдөлд үндэслэж санхүүгийн тайланд толилуулсан хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнийн хэмжиж бодит үнэ цэнийн түвшинд ангилахдаа дараах түвшинг хэрэглэдэг. Үүнд:

Компани нь үнэлгээний техникүүдийг ашиглан санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тодорхойлох, толилуулахдаа дараах түвшнийг хэрэглэдэг. Үүнд:

Түвшин 1: хөрөнгө, өр төлбөрийн хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй (залруулаагүй) идэвхитэй зах зээл дээрх үнэ,

Түвшин 2: бүртгэсэн бодит үнэ цэнэд томоохон нөлөө үзүүлэх бүх өгөгдлүүдийг нь шууд болон шууд бусаар ажиглах боломжтой бусад техникүүд,

Түвшин 3: бүртгэсэн бодит үнэ цэнэд томоохон нөлөө үзүүлэх, ажиглаж болохуйц зах зээлийн өгөгдөл дээр суурилсан өгөгдлүүдийг ашигладаг техникүүд,

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

30. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮРҮҮДИЙН БОДИТ ҮНЭ ЦЭНЭ (ҮРГЭЛЖ.)

Компаний санхүүгийн хөрөнгүүдийн тооцоолсон бодит үнэ цэнэ болон бүртгэгдсэн дүнгийн харьцуулалтыг төрлөөр нь доор үзүүлэв.

	2017	2016
	Мян.төг	Мян.төг
	Түвшин 2	Түвшин 2
Хөрөнгө		
Засгийн газрын үнэт цаас	<u>2,462,701</u>	<u>14,999,930</u>

Хүү бодогддог засгийн газрын үнэт цаасны бодит үнэ цэнийг бусад ижил нөхцөл байдал, үлдэгдэл төлбөрийн хугацаан дээр тулгуурлан, хүүгийн түвшинг ашиглаж ирээдүйн мөнгөнийн үнэ цэнийг бууруулах замаар тодорхойлдог.

31. МОНГОЛ ХЭЛ ДЭЭРХ ОРЧУУЛГА

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Англи хэл дээр мөн бэлтгэсэн болно. Монгол, Англи хувиудын хооронд утга, агуулгын зөрүү гарах тохиолдолд Англи хувийг дагана.

ХАВСРАЛТ

2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ДАВХАР ДААТГАЛЫН КОМПАНИЙН АШИГ АЛДАГДАЛ БОЛОН ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ МАЯГТЫН ДАГУУХ ТОЛИЛУУЛАГА

	2017 Мян.төг	2016 Мян.төг
Даатгалын нийт хураамжийн орлого	1,851,623	994,613
Давхар даатгалын хураамж	(800,423)	(352,811)
Даатгалын цэвэр хураамжийн орлого	1,051,200	641,802
Нийт төлсөн нөхөн төлбөр	—	(4,614)
Нөөц сангийн өөрчлөлт	(206,218)	(367,344)
Нөхөн төлбөрийн цэвэр зардал	(206,218)	(371,958)
Хөрөнгө оруулалтын орлого	5,814,162	4,439,231
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	18,364	2,712
Үйл ажиллагаа, ерөнхий удирдлагын зардал	(1,908,233)	(1,534,775)
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	(45,581)	(742)
Татвар төлөхийн өмнөх ашиг	4,723,694	3,176,270
Орлогын татварын зардал	(404,011)	(195,621)
Татварын дараах ашиг	4,319,683	2,980,649

ХАВСРАЛТ

2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ДАВХАР ДААТГАЛЫН КОМПАНИЙН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ МАЯГТЫН ДАГУУХ ТОЛИЛУУЛАГА

	2017 мян.төг	2016 мян.төг
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	363,229	639,221
Биет бус хөрөнгө	423,300	467,660
	<u>786,529</u>	<u>1,106,881</u>
Эргэлтийн хөрөнгө		
Хадгаламж, хадгаламжийн сертификат, үнэт цаас	41,635,403	32,889,362
Давхар даатгалын хойшлогдсон хураамж	205,193	428,089
Бараа материал	—	8,312
Урьдчилж төлсөн зардал болон бусад авлага	315,597	721,782
Даатгалын хураамжийн авлага	20,721	128,953
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	431,186	231,318
	<u>42,608,100</u>	<u>34,407,816</u>
НИЙТ ХӨРӨНГӨ	<u>43,394,629</u>	<u>35,514,697</u>
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Эздийн өмч		
Эзэмшигчдийн өмч	15,000,000	15,000,000
Эздийн өмчийн бусад хэсэг	489,264	684,333
Хуримтлагдсан ашиг	7,669,695	5,384,758
Нийт эздийн өмч	<u>23,158,959</u>	<u>21,069,091</u>
Өр төлбөр		
Хамтын эрсдлийн сан	1,165,807	846,426
Эрсдлээс хамгаалах сан	3,270,696	3,065,791
Алдагдлаас хамгаалах сан	15,000,000	9,500,000
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц	460,217	1,008,702
ААНОАТатварын өглөг	131,002	21,519
Урьдчилж олсон орлого болон бусад өглөг	105,950	3,168
Давхар даатгагчид өгөх өглөг	101,998	—
Нийт өр төлбөр	<u>20,235,670</u>	<u>14,445,606</u>
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	<u>43,394,629</u>	<u>35,514,697</u>

ХАВСРАЛТ

**2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ДАВХАР
ДААТГАЛЫН КОМПАНИЙН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ МАЯГТЫН ДАГУУХ ТОЛИЛУУЛАГА**

	Эзэмшигчдийн өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт
	Мян.төг	Мян.төг	Мян.төг	Мян.төг
2016.01.01-ний өдрийн байдлаар	15,000,000	86,477	2,404,109	17,490,586
Нийт дэлгэрэнгүй орлого	—	—	2,980,649	2,980,649
Өмчид гарсан өөрчлөлт	—	597,856	—	597,856
2016.01.01-ний болон 2017.1.1-ний өдрийн байдлаар	15,000,000	684,333	5,384,758	21,069,091
Алдагдлаас хамгаалах сангийн нэмэгдэл	—	—	(2,000,000)	(2,000,000)
Өмчид гарсан өөрчлөлт	—	(195,069)	(34,746)	(229,815)
Нийт дэлгэрэнгүй орлого	—	—	4,319,683	4,319,683
2017.12.31-ний өдрийн байдлаар	<u>15,000,000</u>	<u>489,264</u>	<u>7,669,695</u>	<u>23,158,959</u>